

SAIGA NEWS

Мэдээ



6 хэл дээр, болон бөхөн хамгаалах, экологийн талаар мэдээлэл солилцох Нийтэлсэн



© А. Гилёв, К. Каренина

Дэмжлэгтэйгээр
Нийтэлсэн:



Нэмэлт дэмжлэг:



АГУУЛГА

Редакторын зүгээс

Бөхөнгийн мэдээ 10 жилийн ойгоо тэмдэглэж байна!

Шинэ мэдээ

Наталья Якушева Бөхөн хамгаалалд бий болсон дэвшил: Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах конвенцийн (ЗАНЗХК) бөхөн хамгааллийн санамж бичигт оролцогч талуудын 3 дахь уулзалт

Е.Ж. Милнер-Гулланд Ташкент хотноо бөхөн хамгаалагчдын уулзалт болов

Стефан Зутер Бетпак-далагийн популяцид 2015 оны 5 сард тохиосон бөхөнгийн хорогдол

Мария Воронцова Гал түймэрт нэрвэгдсэн байдал

Евгения Самтанова & Наталья Шивалдова “Арлын хамгааллын найзууд” – хил хязгааргүй хөдөлгөөн

Хэвлэлийн мэдээ

Якутад эртний бөхөнгийн гавлын яс олдлоо

Кыргызстанаар дамжин Хятадад гарч буй бөхөнгийн эврийн хууль бус худалдаа

Казахстанд бөхөн агнуур зохион байгуулалттай гэмт хэрэг болж байна.

Бөхөн ОХУ-ын Улаан номонд бүртгэгдэнэ

Өгүүлэл

Кристина Рысава Газрын мониторинг судалгааны ач холбогдол: Бөхөнгийн газрын судалгааны түүх

Андрей Гилев & Кристина Каренина Астрахан мужийн Степной ДЦГ-ын бөхөнд гүний худгийн үзүүлэх нөлөө

Лаура Кор болон бусад. Укбезийн Устюртийн өндөрлөг дэхь бөхөнг хууль бусаар хэрэглэхэд хүргэж буй хүчин зүйлийг ойлгох нь

София Еллиот болон бусад. Өсвөр насныханы мөрөөдөл: Казахстанд шинэ хамгаалалын санаачлагад өсвөр насныханы хүсэл эрмэлзлийг ашиглах болно?

Зиганг Жианг Хятадын уламжлалт анагаах ухаанд ашиглагдаж буй бөхөнгийн эврийг тодорхойлоход ДНХ-ийн баркодийн технологийг ашиглах нь

Шинэ хэвлэл

Урсзула Ратажзак болон бусад Зүүн Европ болон Сибириэс олдсон бөхөнгийн 4 дэхь толгой: *Saiga borealis* болон *Saiga tatarica* нь нэг зүйл үү эсвэл хоёр зүйл үү?

Зарлал

Бөхөнгийн нөөцийн төвийн талаарх шинэ мэдээ

Бөхөнгийн баатар

Юрий Арылов, ОХУ

Редакторын баг. Хятад: А.Канг (akang@wcs.org) & Фенглиан Ли (fli@wcs.org) ЗАХН, Хятад дахь хөтөлбөрийн газар, ; Казахстан: Профессор А.Бекенов & док Ю.А.Грачев, Амьтан судлалын хүрээлэн (teriology@mail.ru)&Алена Чукатина КБТЗХН, (alyona.chukatina@acbk.kz); Монгол: доктор Б.Лхагвасүрэн ЕСБХүрээлэн (lkhagvazeer@gmail.com) & Б.Чимэддорж (chimeddorj@wwf.mn), ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар; Орос: Профессор Ю. Арылов, Халимагийн БНУ-ын Зэрлэг амьтан судлах төв (saiga-center@mail.ru) & док А. Луцкекина, Экологи эволюцийн хүрээлэн (saigak@hotmail.com); Узбекстан: Е. Быкова [Гүйцэтгэх редактор] & док А. Есипов, Амьтан, ургамлын генийн сангийн хүрээлэн (esipov@xnet.uz); Их Британи: Профессор Е.Ж. Милнер-Гулланд [зөвлөх редактор], Охфордийн их сургууль (ej.milner-gulland@zoo.ox.ac.uk) & доктор Давид Маллон [Шүүмжлэгч], ДБХХ, Туруутны мэргэжлийн баг, d.mallon@zoo.co.uk; График дизайныг А. Ганиева (Alfiya_71@mail.ru).

Бүх өгүүллийг бидний хэрэглэдэг 6 хэлний аль нэг дээр бичнэ үү. Өгүүллийг esipov@xnet.uz хаягаар эсвэл редакторуудын аль нэг рүү илгээнэ үү. Бид жилд хоёр удаа гаргадаг. Материалаа esipov@xnet.uz хаягаар эсвэл редакторуудын хэн нэгэнд илгээнэ үү. Сэтгүүл жилд хоёр удаа гардаг. Өгүүлэл бичих журмыг www.saiga-conservation.com хуудсаас эсвэл редакторуудаас англи болон орос хэл дээр авч болно. Хэрвээ танд асуулт гарвал өөрийн улсын Бөхөнгийн мэдээний редактортай эсвэл гүйцэтгэх редактор Елена Быковатай (esipov@xnet.uz) холбогдоно уу.

Энэ дугаарыг онлайн хэлбэрээр www.saiga-conservation.com, <http://saigak.biodiversity.ru/publications.html> болон <http://www.wildlifewarden.net/wcs/mini/saiga-chinese.pdf> сайтуудаас pdf форматаар, эсвэл хүсэлтийн дагуу сэтгүүл хэлбэрээр редакторуудаас англи, казах, хятад, монгол, орос, узбек хэл дээр авч болно.

Редакторын зүгээс

Бөхөнгийн мэдээ 10 жилийн ойгоо тэмдэглэж байна!

2004-2005 онд бөхөн нь олон улсын хэмжээнд өндөр ач холбогдол бүхий зүйл болсон ба уг зүйлийн хамгаалах зорилгоор 2006 онд ЗАНЗЖК-ийн харилцан ойлголцлын санамж бичгийг бий болгоход түлхэц өгсөн. Олон улсын энэхүү анхаарал хандуулж байгааг тооцохгүйгээр уг зүйлийн эколги хамгаалал болоод олон улсын түвшинд мөн тархац нутгийн хүрээнд судлах, хамгаалах талаарх хийгдэж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл солилцох ямар нэгэн механизм байхгүй байсан. Бөхөн хамгаалагчдын хийж буй хамгийн сайн ажлууд ялангуяа бүс нутгийн хэмжээнд хийгдсэн ажлууд хэлний асуудлаас шалтгаалан хэвлэгддэггүй, эсвэл үүнийг уншдаггүйгээс хүмүүст хүрдэггүй байсан. Иймээс нийгмийн бүх хүрээлэлд зориулсан түүх, судалгааны өгүүлэл, хэвлэлийн болон зар мэдээний холимог бүтээл болох Бөхөнгийн мэдээ төрөн гарсан. Энэ үеэс эхлэн бөхөнгийн тархац нутгийн янз бүрийн хэсэгт ажиллаж буй багш, албан тушаалтан, судлаачид, хууль сахиулагчид зэрэг олон хүн Бөхөнгийн мэдээнд мэдээгээ бичиж эхэлсэн. Энэхүү товхимол алслагдсан тосгод, яам, тамгын газар, олон улсын төрийн бус байгууллагуудад хүргэгдэн уншиж байна. Бид энэ ховордсон зүйлийн талаарх мэдээллээр нийгмийг сэрээсэн, энэ сэтгүүлд сэтгэл хангалуун байдаг бөгөөд манай редакторын багийнхан Бөхөнгийн мэдээний талаарх санал сэтгэгдлийг харуулахыг зорилоо.

Елена Быкова (Гүйцэтгэх редактор) ба & Е.Ж.Милнер-Гулланд (Зөвлөх редактор)



Анна Луцкекина: 10 жилийн туршид шинэ дугаарыг бэлтгэхдээ энэ сэтгүүлийн олон жилийн хамтрагч, ивээн тэтгэгч байсаар олон олон найз нөхөдтэй уулзах боломж олгосоор ирсэн. Бөхөнгийн тархац нутгийн янз бүрийн хэсэг дэхь сонирхолтой, ач холбогдолтой зүйлүүдийг, мөн өнгөрсөн үеийн хувь тавилан, одоо тулгарч буй асуудал, ирээдүйн итгэл найдварын талаар шинэ шинэ мэдлэгийг олж аван суралцаар байна.

Буянаагийн Чимэддорж: Редакторын зөвлөлийн гишүүний хувьд, миний бие Бөхөнгийн мэдээг уншихдаа орон нутгийн бүлэг нөхөрлөлд түшиглэсэн бөхөн хамгааллын өөр өөр улс орны туршлагаас суралцахдаа маш их баяртай байдаг. Энэ нь мөн янз бүрийн салбарт гарсан дэвшлийг бөөгнөрүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулж байна. Бөхөнгийн мэдээ нь ялгаатай соёл, зан заншил, амьдралын янз бүрийн арга замыг нэгтгэн бөхөн хамгаалалд оруулах нэг дуу хоолой болгоход тусалж байна. Бөхөн хамгаалах нийгэмлэг нь нийгмийн янз бүрийн давхаргын уншигчдад Бөхөнгийн мэдээг хүргэх талаар бодох хэрэгтэй.

Дэвид Маллон: Бөхөн мэдээ хэвлэгдэж эхлэснээс хойш маш өндөр шаардлагад нийцсэн бөхөнгийн янз бүрийн асуудлыг хамарсан өгүүлэл тогтмол хэвлэгдэж байгаа билээ. Олон гайхалтай зүйлийн нэг нь хэд хэдэн хэлээр гаргаж буй Бөхөнгийн мэдээ нь энэ талаар гаргаж буй анхны хэвлэл бөгөөд бөхөн хамгаалалд гол үүрэгтэй зүйл юм.

Бадамжавын Лхагвасүрэн: Миний бие Бөхөнгийн мэдээнд өөрийн үүргээ биелүүлж байгаагаас илүүтэйгээр бөхөнгийн судалгаа, хамгаалал, хамтын ажиллагааны талаарх энэхүү гайхалтай, ач холбогдолтой цувралын редакторын зөвлөлийн гишүүн болсондоо баяртай байдаг. Бөхөнгийн мэдээ нь уг зүйлийн судалгаа, хамгааллын талаар ажиллаж буй судлаачид мэргэжилтнүүдийг бүгдийг нэг дор зангидаж чадсанаараа анхдагч бөгөөд үндэсний болон дэлхийн түвшинд уг зүйлийг хамгаалан үлдээхэд чиглэгдсэн олон улсын конвенци шийдвэр гаргагч нарт зориулсан олон улсын арга хэрэгсэл мөн.


Айли Канг: Миний хувьд Бөхөнгийн мэдээ нь зөвхөн бөхөн хамгаалалд оролцож буй янз бүрийн талуудыг төлөөлөөд зогсохгүй бид юу хийж болох талаар алсын харааг өгдөг үндсэн суурь юм. Өнөөгийн бөхөнгийн популяцид тулгарч буй бэрхшээл нь бид цаашид юу хийх хэрэгтэйг сануулсан дохио бөгөөд Бөхөнгийн мэдээ энэ талаарх цаашид юу хийхийг харуулсан нэг зүйл юм.

Стефен Зутер: Одоогоор 10 жилийн нүүр үзэж буй Бөхөнгийн мэдээ нь бөхөн гөрөөс буюу хосгүй гайхамшигт энэ амьтны хамгааллын талаар мэдээлэл солилцох ихээхэн чухал холбогдол мэдээллийн хэрэгсэл юм. Энэ нь бөхөн хамгаалах талаар ажиллаж буй хүн бүрт, уг зүйлийг сонирхож буй хүмүүст мэдээлэл өгдөгөөрөө ихээхэн ач холбогдолтой.

Фенглиан Ли: Бөхөнгийн мэдээнээс бусад улс оронд хийгдсэн бөхөнгийн талаарх мэдээллээс их зүйлийш суралцсанаар эн тэргүүнд манай багийн ажлын үр дүнд ихээхэн хувь нэмэр болж байна. Олон хятад хүмүүс бөхөнгийн талаар илүү их зүйлийг суралцах хэрэгтэй байдагаас Хятадын талаас редакторын зөвлөлийн гишүүн болсон. Энэ бол Бөхөнгийн мэдээний зорилго гэж би бодож байна.

Юрий Грачев: 10 жилийн өмнө Бөхөн хамгаалах нийгэмлэгийг үүсгэн байгуулах үед Е.Ж, Милнер-Гулланд бөхөн мэдээний талаар санаа өгсөн. Энэ цагийг эргэн сөхвөл энэ санааны хэрэгжилт, үр дүнгийн талаар бидэнд зарим нэг эргэлзээ байсан хэдий удалгүй энэ бүгд сарнин алга болсон. Олон нийт эхний хэвлэлийг маш их сонирхож байсан. Дараа дараачийн удаа, хэвлэн нийтлэгдэж буй сэдэв болоод зохиогчдын тоо өргөжсөн бөгөөд уншигчид энэ шинэ мэдээллийн эх сурвалжаас бөхөнгийн тархац бүхий бүх улс орны хэмжээнд бөхөнд тулгарч буй зүйлийг мэдэх, судлахад ихээхэн ач холбогдолтой байсан. Энэхүү сэтгүүлийн бөхөнгийн хамгаалал, экологийн талаарх мэдээллийг солилцох гол зорилго нь бүрэн хэрэгжиж байгаа бөгөөд цаашид Бөхөнгийн мэдээ үргэлжлэх болно.

Александр Есипов: Миний хүсэж, хүлээж байсан үр дүнгээс ч илүү байна. Бид зайлшгүй шаардлага бүхий санхүүжилт хүлээн авсан бөгөөд олон санаанууд гарч байсан. Бөхөн хамгаалалд оролцож буй хүн бүр тэдгээрийн ажилд ихээхэн ач холбогдолтой хэрэгсэлтэй байх хэрэгтэй. Бүх цувралууд 6 хэл дээр онлайн хэлбэрээр байгаа нь маш сайн юм. Энэ цуврал нь ирээдүйд хэрэглээгээ даган улам бүр өргөжих болно гэдэгт би үнэхээр итгэлтэй байна. Өгүүлэл дээр суурилсан ном болгон хэвлүүлэх цаг нь болжээ. Оролцож буй бүх хүмүүст баярлалаа !



© А. Гилёв., К. Каренина

Шинэ мэдээ

Бөхөн хамгаалалд бий болсон дэвшил: Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах конвенцийн (ЗАНЗХК) бөхөн хамгааллийн санамж бичигт оролцогч талуудын 3 дахь уулзалт

Наталья Якушева, ЗАНЗХК, нарийн бичгийн дарга нарын газар, natalya.yakusheva@cms.int



Техникийн зөвлөгөөний үеэр илтгэл хэлэлцүүлж байгаа нь © А.Есипов

Нарлаг Ташкент хотноо 2015 оны 10 сарын 26-29 нд ЗАНЗХК-ийн бөхөн хамгаалал, нөхөн сэргээх, тогтвортой ашиглах харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурагч талуудын гуравдах уулзалт болсон. Төр засгийн байгууллага, олон улсын байгууллага, ТББ болон шинжлэх ухааны академийн төлөөлөл болсон 17 гаруй оролцогчид Казахстан, Монгол, ОХУ, Туркменистан, Узбекистаны бөхөнгийн популяцийг нөхөн сэргээх арга хэмжээний тодорхой багцыг зөвшилцөхөөр цугларсан. Бөхөн судлаачдын хурал болон Бөхөн хамгаалах нийгэмлэгийн жил тутмын хурал мөн уг үеэр болсон бөгөөд халдварт өвчний дэгдэлт, дэд бүтэц, хууль бус худалдаа, орон нутгийн хамгааллын үйл ажиллагаа зэрэг асуудлыг илүү гүнзгийрүүлэн хэлэлцсэн нь ихээхэн чухал ач холбогдолтой байсан.

Уг уулзалт нь бөхөн хамгааллын үйл ажиллагааны цогц болох Олон улсын дунд хугацааны ажлын хөтөлбөрт заагдсанаар 2015 болохоор урьдчилан төлөвлөгдсөн байсан. Казахстанд 150000 гаруй бөхөн бөөнөөрөө хиарсаны дараагаар уг уулзалтыг зохион

байгуулах шаардлага илүү чухал болж ирсэн. Бөхөн бөөнөөрөө хиарсан нь бүх дэлхий даяар хэвлэл мэдээллийн хэрэгслээр энэ зүйлийг хамгаалах талаар урьд өмнө байгаагүй анхаарлыг татаж, тодорхой хэмжээгээр хөрөнгө босгох ажлыг хөнгөвчилсөн. Цаашилбал, энэ нь төрийн албан хаагчид болон хамгааллын үйл ажиллагаа явуулж байгаль хамгаалагчид гэсэн ердийн тойргийн гадна талд бөхөн хамгаалахын ач холбогдлын талаарх мэдээллийг түгээх давалгааг бий болгосон байна. Бага зэргийн дэс дарааллын болон зарчмын зүйлсийг эс тооцвол уг хурал өөрийн зорилгоо биелүүлж, оролцогчид бөхөн хамгааллын талаарх цаашид баримтлах зүйл дээр санал нэгдсэн билээ.

Бөхөн хамгаалах харилцан ойлголцлын санамж бичиг нь таван улс (Казахстан, Монгол, Орос, Туркменистан, Узбекистан) гарын үсэг зурсанаар 2006 онд хүчин төгөлдөр болсон ба бөхөн хамгаалах чиглэлээр есөн байгууллага хамтран үйл ажиллагаа явуулж байна.

Бөхөн хамгаалахаар үүрэг хүлээсэн Засгийн газар, бусад байгууллага, иргэдийн хамтын

Шинэ мэдээ (үргэлжлэл)

хүчин чармайлтын үр дүнд бүх цаг үеийн хамгийн доод үзүүлэлт болох 2000 оны эхээр 50000 орчим тоо толгойтой байсан популяцийг нөхөн сэргээхэд ихээхэн нөлөө үзүүлсэн.

Гэсэн хэдий ч халдварт өвчний дэгдэлт, дэд бүтцийн эрчимтэй хөгжил, хулгайн анг үүсгэж буй үндсэн шалтгаан болох хууль бус худалдаа зэрэг удаан хугацаанд байнга учирч буй аюул занал нь бөхөнд тулгарч буй шинэ сорилт болж байна. Хил дамнасан Устюртын популяцид ихээхэн хөнөөлтэй хүчин зүйл нь Казахстан, Узбекистаны хооронд хил дамнасан хилийн хашаа болон төмөр зам бөгөөд энэ нь тэдгээрийн шилжилт хөдөлгөөнийг устаж үгүй болгоход хүргэнэ. ЗАНЗХК-ийн санамж бичиг нь бөхөн хамгаалах зорилгоор хэрэгжиж буй бусад олон улсын гэрээний хувьд шүхэр бөгөөд

тэргүүлэх чиглэлийг тогтоох, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилготой билээ.

Гэсэн хэдий ч бодит арга хэмжээ, үр дүн нь бүр энэ өвөрмөц тал хээрийн зүйлийг хамгаалахаар сонирхсон хүн бүрийн үүрэг, оролцооноос ихээхэн хамааралтай. Энэхүү гуравдах уулзалт нь “бөхөнгийн хамт олон” илүү их үр дүнг авчрах шинэ ажилд бэлэн байгааг дахин нэг удаа харууллаа.

Илүү мэдээлэл, хурлын баримт бичгийг доорхи хуудаснаас олж болно <http://www.cms.int/saiga/en/meeting/third-meeting-signatories-saiga-mou-mos3>

Зураг 1. Зураг 2. Техникийн зөвлөгөөний үеэр илтгэл хэлэлцүүлж байгаа нь

Ташкент хотноо бөхөн хамгаалагчдын уулзалт болов

Е.Ж. Милнер-Гулланд, Бөхөн хамгаалах нийгэмлэг, ej.milner-gulland@zoo.ox.ac.uk



Максет Косбергенов, 2015 оны шилдэг бөхөн хамгаалагч шагналыг хүртэгч (© А.Есипов)

Бөхөн хамгаалах талаар харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан талуудын саяхан (2015 оны 10-р сарын 26-29-нд) болсон уулзалт нь НЗХОУК-ийн Нарийн бичгийн дарга нарын газар, Бөхөн хамгаалах нийгэмлэг, ДБХХ-ны Туруутны мэргэжлийн группын техникийн зөвлөхүүд, түүнчлэн Узбекистан дахь урьж, хүлээн авсан хүмүүсийн ажлын үр дүнгээ дүгнэх оргил үе байв. Энэ нь сүүлийн хэдэн жилийн турш бөхөн хамгаалагчид,

судлаачид өнөөг хүртэл хийсэн өөрсдийн ажлын үр дүнг танилцуулж, чөлөөт ярилцлага хийж, заримдаа санаа бодлоо солилцох боломж олгосон.

Эцэст нь хэлэхэд, бөхөн хамгааллын тэргүүн эгнээнд зогсож буй үл мэдэгдэх баатруудын хүрсэн амжилтыг тэмдэглэх, хуучин найз нөхөд, хамтран ажиллагсадтайгаа уулзах, шинэ мэдлэг мэдээлэлтэй болохын тулд бөхөн хамгаалах урам зоригийг өгөх боломжийг бий болгосон.

Тухайн зүйлд маш олон бэрхшээл учирч, бөхөн хамгаалалд тулгарч буй хүнд хэцүү энэ үед тодорхой хугацаанд төлөвлөгдсөн зорилго, зорилтоо шинэчлэх боломж өглөө. Миний хувьд бид хамтдаа аливаа зүйлийг хамгийн сайн талруу нь өөрчлөх хангалттай хүчтэй юм байна гэсэн итгэлийг надад өгсөн.

Уулзалтын эхэнд бөхөн хамгааллын чухал асуудлуудыг хамарсан 2 өдрийн хурал болсон. Энд 2015 оны 5 сард Казахстанд болсон бөхөн бөөнөөрөө хиарсан тухай сүүлийн үеийн мэдээ, хууль бус агнуур, худалдаа болон дэд бүцтийн өнөөгийн хөгжил зэргийг хамарсан илтгэлүүд хэлэлцэгдсэн. Энэ өдөр албан ёсны төлөөлөгчдийн гишүүд, түүнчлэн урьж оролцуулсан судлаачид маш сайн оролцсон ба



Залуу хамгааллын удирдагч 2014-2015 оны ялагчид. (© А.Есипов)

уулзалтын өрөөнд, кофе завсарлагааны аль алинд нь маш их эерэг хэлэлцүүлэг явагдаж байв. Ажил хэрэгч уур амьсгал нь албан ёсны уулзалтанд шаардагдах бичиг баримтыг боловсронгуй болгох, сэдэв тус бүрийн хувьд чухал асуудал, шийдлийн талаарх хүлээн зөвшөөрөгдсөн хураангуйг бэлтгэхэд бидэнд тусалж байсан. Эдгээр тайланг ЗАНЗХК эцэслэж байгаа бөгөөд удахгүй бэлэн болно.

Уулзалтын албан ёсны хэсэг илүү их байсан бөгөөд хүмүүс техникийн уулзалтын дараа их ядарсан байсан. Гэсэн хэдий ч, хамгийн ач холбогдолтой нь бидний гол баримт бичгүүдийг зөвшөөрсөн явдал бөгөөд энэхүү тойм тайлан нь одоогийн тархац хүрээнд бөхөнгийн популяцийн төлөв байдал, түүнийг хамгаалах талаар авсан арга хэмжээ, дунд хугацааны олон улсын ажлын хөтөлбөрийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн тунхаглал юм. Энэхүү үйл ажиллагааны урьдчилсан жагсаалт нь ирэх таван жилд бидний хөрөнгө босгох, үйл ажиллагаа явуулах, үнэлэх үйл явцын үндэс суурь болж байна. Бөхөн нь олон улсын зөвшилцлийн үр дүнд ийм тодорхой, хүчтэй үйл ажиллагааны төлөвлөгөө бүхий зүйл байсаар байна. Бүх ховордож буй зүйлд өгч буй тусламж, анхаарлын нийлбэр ийм байвал хамгаалал нь илүү өндөр түвшинд байх болно.

Пүрэв гаригт үдээс хойш болсон хурлыг миний хувьд онцлон хэлмээр байна. Энэ нь

Бөхөн хамгаалах холбооны шагнал гардуулах ёслол байсан ба бөхөн хамгаалах чиглэлээр ажилладаг хүмүүс хувийн шугамаар өөрсдийн ажлын тухай ярилцаж байсан нь хүмүүст хамгийн их урам зориг өгсөн явдлын нэг байв.

Тэд хамгааллын тэс өөр арга барилын тухай бидэнд ярьж, бөхөн бүхий нутгийн хүүхдүүдээр ханын зураг зуруулах, сонин гаргах зэрэг авъяас чадварт суурилсан бодлого түлхүү явагддаг байна. Залуу үеийн хамгааллын удирдагчдад урам хайрласан зүйл болох хулгайн ангийн эсрэг шилдэг тэмцэгчдэд зориулсан манай шагналын ялагч нь бэрхшээлтэй тулгарсан үед урт удаан хугацаанд ямар тэсвэр тэвчээр гаргадгиын илэрхийлэл юм. Эдгээр хүмүүсийн ярихыг сонсох нь нэр төрийн хэрэг бөгөөд, олон улсын форумын энэхүү шагнал тэдний хэцүү ажлыг хүлээн зөвшөөрч үнэлсэн явдал байлаа.

Баасан гаригийн өглөө Бөхөн хамгаалах нийгэмлэгийн уулзалт болсон. Бид энд БХН-ийн шинэ найзуудаа болон удаан хугацаанд хамтран ажиллаж байсан хүмүүсийг хамт урьж оролцуулсан. Бид хуучин анд Анна Луцкекина болон Удирдах зөвлөлөөс бөхөн хамгаалалд элсэн орж буй шинэ цэрэг болох Алёна Чукатина нарыг урьсан. Алёна аль хэдийн Бөхөнгийн нөөцийн төвийн вэб хуудсыг бий болгоход олон улсын хамтын ажиллагаагаараа асар их хувь нэмэр оруулж, бөхөн хамгаалалд түүний гүйцэтгэсэн үүргийг үнэлсэн юм. Уг

Шинэ мэдээ (үргэлжлэл)

хурал нь дараагийн жилүүдэд биелүүлэх шинэ, шинэлэг арга барил болон БХН-ийн эрхэм зорилго, стратегийг зохион байгуулалттай цуврал ярилцлагаар өндөрлөсөн.

Ташкентаар хийсэн хаалтын аялал нь эрчимтэй ажилласан хэд хоногийн дараах намрын нар жаргахыг харах сайхан боломж байсан бөгөөд бэлэн улс орноос ирсэн оролцогчид хамтран хэлэлцсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд бэлэн гэр гэртээ буцсан.

Тэд өмнөө тулгарч буй асар том асуудлын хэцүү тал болоод ашиг тусыг мэдэрч, дэлхий эргэн тойрон буй яамд, ТББ, шинжлэх ухааны хүрээлэнгүүдэд ажиллаж буй хамтран зүтгэгчдийн халуун дулаан уур амьсгалыг

мэдэрч, өөрсдийн тавьсан зорилгодоо хүрэхийн тулд санхүүжилт болон туршлага солилцох талаар хамтран ажиллахад бэлэн болохыг ойлгосон. Бөхөнгийн төлөө нэгдэцгээе!

ЗАНЗХК-ийн хурлын баримт бичиг, уулзалтын хэсэг тус бүрт хэлэлцэгдсэн PPT-г доорхи холбоосоор онлайнар авч болно: <http://www.cms.int/en/meeting/third-meeting-signatories-saiga-mou-mos3#collapse1529>.

Бөхөн хамгаалах нийгэмлэгийн уулзалтын тайлан, шинэ төлөвлөгөөг уг хуралд оролцосн бүх хүмүүст удахгүй илгээх болно. Хэрвээ та тэнд байгаагүй боловч хуулбарыг авахыг хүсвэл mail@saiga-conservation.com –т хандана уу.

Бетпак-далагийн популяцид 2015 оны 5 сард тохиосон бөхөнгийн хорогдол

Стефен Зутер КБТЗХН, steffen.zuther@acb.kz

Бөхөнгийн мэдээ 19-д дурьдсанчлан, 2015 оны тавдугаар сарын дундуур Казахстаны Костанай мужийн өмнөд хэсэгт Бетпак-Далагийн популяцид төллөлтийн үеийн томоохон бөөгнөрөл үүсэх үед бөхөн бөөнөөр хиарч эхэлсэн. Энэ үзэгдэл бараг нэг сарын турш үргэлжилсэн ба популяцийн тархац нутгийн хүрээнд төллөлтийн үед үүссэн томоохон бөөгнөрөл бүрт нөлөөлсөн. Мал эмнэлгийн алба нэн даруй уг өвчний дэгдэлтийг судлах лабораторийн шинжилгээнд шаардлагатай дээж цуглуулах, үхсэн амьтдыг шатаах ажлыг эхэлсэн байна. Хөдөө аж ахуйн яамны ойн аж ахуй, агнуурын хорооны удирдлага дор эрх бүхий байгууллагууд бөхөн олноор хорогдсон алслагдмал газрын шаардлагатай хүний болон техникийн хүчин чадлыг бүрдүүлэхэд асар их хүчин чармайлт гаргасан. Эцэст нь хэлэхэд, 150044 үхсэн амьтдыг зохих журмын дагуу устгал хийсэн ч тал хээрийн өргөн уудам талбайд үүнээс ч олон амьтан үхсэн байж магадгүй юм. Алтын Дала байгаль хамгаалах санаачлага төсөл, Казахстаны БТЗХНийгэмлэг болон Лондонгийн Эзэн хааны Мал эмнэлгийн коллежийн оюутнуудын хамтарсан баг уг газарт эхнээс авхуулаад дуустал нь ажилласан.

Үнэн хэрэгтээ, уг баг өмнөх жилийн ажлыг үргэлжлүүлэн бөхөнгий төллөлтийн үеийг судлах зорилготой байсан. Гэсэн хэдий ч үхсэн амьтдын сэг эхний өдрөөс тохиолдож үхсэн бөхөнгийн шинж тэмдэг баримтжуулахад гол анхаарлаа хандуулав.

Халдварт өвчний дэгдэлтийн эхний өдрөөс манай баг халдварт өртсөн амьтад дээр ажиглалт явуулах, малын эмч нарын дэмжлэгтэй тэдгээр сэг зэмийг хайх, дээж авах ажлыг эхлэсэн. Энэ ажилд 2012 оноос КБТЗХН болон Лондонгийн мал эмнэлгийн коллежийн ажил хэргийн түнш байсаар ирсэн Био аюулгүй байдлын судалгааны хүрээлэнгийн судлаачид мөн оролцсон.

Уг хам шинжээр өвчилсөн бөхөн нь маш сул дорой, стресст орсон байдалтай байж, толгойгоо өндийлгөх болон явах чадвараа алдсан байсан. Зарим үед тэд зүгээр л газар хэвтэж байх боловч үргээхгүй бол дахиж өндийж босч ирэхгүй байв. Эдгээр амьтдад суулгах үзэгдэл нэмэгдэж, хамар болон амнаас салсархаг шүүрэл ялгарч байсан. 2010 болон 2011 онд тохиолдсон бусад хорогдол шиг үхсэн амьтдын бие хавдсан шинж тэмдэг ажиглагдаагүй (БМ-11,12,13-аас хар). Амьсгал

авахад улам бүр хэцүү болсоноор эцэст нь тэд босох чадвараа алдаж, үхдэг. Эдгээр үе шатууд нь хэдхэн цагийн турш үргэлжилж буй баримтжуулсан байна.

Нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (ЗАНЗХК), Алтын Далагийн байгаль хамгаалах санаачлага, Казахстаны Хөдөө аж ахуйн яамны дэмжлэгтэйгээр томилсон шинжээчийн зорилго нь тавдугаар сарын сүүлээр Акмола мужийн хойд хэсэгт бөхөн бөөнөөрөө хиарсан газрыг мөн хамруулах явдал байв. Лондонгийн мал эмнэлгийн сургууль, НҮБ-ын ХХААБайгууллага, Био аюулгүй байдлын судалгааны хүрээлэнгийн судлаачид хэд хэдэн үхсэн амьтныг задлан шинжилсэн. Урьдчилсан оношоор цусархаг үжил илэрсэн ба лабораторийн судалгааны эхний үр дүн нь *Pasteurella multocida* нянгийн В дэд хэв шинж мөн илэрсэнд, энэхүү бөөнөөрөө хиарах үзэгдлийн цаад гол эмгэг болохыг тогтоосон. Энэ нянгийн халдварыг хэд хэдэн лабораторид баталгаажуулсан байна. *Clostridia perfringens* омогн мөн илэрсэн. Бүх мэргэжилтнүүд эдгээр нянгаас ялгаруулсан хорт бодис нь бөөнөөрөө хиарсан шалтгаан гэдгийг хүлээн зөвшөөрсөн хэдий ч энэ халдварын дэгдэлтэнд юу нөлөөлж байгаа нь тодорхой бус байна.

Хэд хэдэн судалгаагаар энэ асуудлыг шийдвэрлэж эхлээд байна. Хөдөө аж ахуйн яам бөхөн бөөнөөрөө хиарсан талаарх дүгнэлт гаргаж, дараагийн алхмуудыг тодорхойлох, санхүүжилтийг хэлэлцэх зорилгоор мал эмнэлгийн шинжлэх ухаан, бөхөн экологийн чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Зургадугаар сарын эцсийн байдлаар, «Охотзоопром» улсын нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр КБТЗХН зохион байгуулсан өөр нэг экспедиц бөхөнгийн өвөлжих газраас төллөх нутаг хүртэлх Бетпак-далагийн бөхөнгийн популяцийн амьдрах орчныг хөндлөн туулжээ. Энэ судалгааны зорилго нь энэ жил бөхөнд ашиглагдсан экосистемд судалгаа хийн, хоруу чанартай байж болзошгүй *Pasteurella* үндсэн шалтгааныг тодорхойлж, аливаа нэг хэвийн бус зүйлийг тодорхойлсноор бөхөн бөөнөөрөө хиарах



Дараагийн шинжилгээг хийх зорилгоор үхсэн бөхөнгөөс дээж авч байгаа нь (© АСБК)

үзэгдлээс урьдчилан сэргийлэх явдал байв. Хөрс, ургамал, усны олон тооны дээжийг цуглуулан лабораторийн шинжилгээ хийсэн. Тухайн бүс нутгийн мал сүрэгт илрэх аливаа өвчин эмгэг бөхөн амджих боломжийн талаар мөн судалсан. Мал бүхий айлуудаас авсан аман асуулгыг дүгнэвэл өмнөх өвчин эмгэг, тэдгээрийн бөхөнд үзүүлсэн бодит нөлөөллийг зураглах боломжтой болно. Гэсэн хэдий ч, өвчин хэд хэдэн газарт илэрч байсан ч, бөхөн олноор хиарсан газартай ямар нэгэн байдлаар холбоогүй байна. Ургамлын судалгааны дүнгээр нүүдлийн зам дагуу болон бөөнөөрөө хиарсан газарт хорт ургамлын элбэгшил ажиглагдаагүй байна. Бөхөн бөөнөөр хиарсан газруудад ургамлын бүлгэмдэл харилцан адилгүй байсан. Бөхөн бөөнөөр хиарах явдалд ургамлын үүрэг онцгой бөгөөд хүрээлэн буй орчны бусад хүчин зүйлтэй хавсарсан нэг ургамлын оролцоо байхыг үгүйсгэх аргагүй. Хөрс, ус, ургамлын дээжинд дүн шинжилгээ хийж байгаа бөгөөд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр таамаглаж байсанчлан ямар нэгэн хорт бодис, түлш, үлдэгдлийг илрүүлж чадаагүй. Үхсэн амьтдаас авсан цусны дээжинд холбогдох лабораторийн шинжилгээг Европын холбооны улсын лабораторид хийсэн боловч одоогоор ямар нэгэн халдварт өвчин үүсгэгч олдоогүй байна. Гэвч үхсэн бөхөнгийн эдийн дээжинд эмгэг судлалын иж бүрэн дүн шинжилгээ хийх зэргээр шинжилгээ үргэлжилсээр байна.

Шинэ мэдээ (үргэлжлэл)



Үхсэн бөхөнгийн шаргачин (© АСБК)

Олон улсын түвшинд, Лондонгийн Мал эмнэлгийн коллежийн удирдлага дор салбар дундын судалгааны баг энэ ер бусын бөөнөөрөө хиарсан үйл явдлын цаад шалтгааныг олохоор ажиллаж байна. Энэхүү багийн гол стратеги нь одоогийн байгаа бүх материалд харьцуулсан дүн шинжилгээ хийх, энэхүү бөөнөөр хиарсан үзэгдлийн онцлог хэв маягийг тодорхойлох зорилгоор өнгөрсөн хугацаанд бөхөн болоод бусад зүйл амьтдад тохиож байсан бөөнөөр хиарах үзэгдлийн

талаар анализ хийх, цаашид хээрийн судалгаагаар дамжуулан нэмэлт мэдээллийг цуглуулах болон Казахстаны засгийн газрыг дэмжлэгтэйгээр стратеги, бодлогын чанарыг сайжруулах явдал юм. Энэ төслийг Их Британи улсын засгийн газрын байгалийн нөөцийн судалгааны төвөөс санхүүжүүлж байгаа бөгөөд 2016 оны зун хүртэл үргэлжилнэ. Эдгээр хүчин чармайлт нь цаашилбал Зэрлэг амьтан хамгаалах сүлжээ, Ховордсон зүйлийг хамгаалах нийгэмлэг, Олон улсын амьтан ургамал хамгаалах сан, Бөхөн хамгаалах нийгэмлэг, Франкфуртын амьтан судлалын нийгэмлэг болон Шувуу судлалын эзэн хааны нийгэмлэгээр дэмжигдэх болно.

Үүний зэрэгцээ, Казахстан улсын Засгийн газар нь бөхөнгийн экологи, мэнд үлдэлт болон бөөнөөр үхэх үзэгдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор судалгааны чанарыг сайжруулах, цаашид хэрэгжүүлэх судалгаа шинжилгээний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж байна. Казахстаны олон эрдэм шинжилгээний байгууллага, олон улсын мэргэжилтнүүд ойрын хугацаанд дуусгасан байх ёстой энэ үйл явцад хувь нэмрээ оруулж байна.

Гал түймэрт нэрвэгдсэн байдал

Мария Воронцова Амьтан хамгаалах олон улсын сангийн ОХУ-ын салбарын ажилтан (IFAW), mvorontsova@ifaw.org

Олон жилийн турш ОХУ-ын Амьтан хамгаалах олон улсын сан (IFAW) Степной дархан газрын ажилтнуудтай дотно, найрсаг харилцаатай хэвээр байна. Бид дахин дахин Астрахань бүс нутгийн энэ гайхамшигтай буланд айчлан, дархан газрын ажилтнуудтай харилцаа тогтоон, тэдний ажлыг харж байна. Бид үргэлж чимээгүйхэн бэлчээрлэх бөхөн, шувуудын сүрэг, зах хязгааргүй тал, амар амгалан байдлыг хараад гайхан биширдэг. Энэ бүхэн бөхөн амьдралынхаа өөр өөр цаг үед амрах, хоргодох оромж нь болдог Степной дархан газрыг хамгаалж буй жижиг бүлгийн хүчин чармайлтын үр дүнд үүсдэг. Жишээ нь, бөхөнгийн усанд орж ирдэг газар нь хээрийн оршин суугчдын хүч хөдөлмөрөөр арчлагдаж байдаг. Бөхөнгийн экологи, зан төрхийн талаарх өөрсдийн сайн мэдлэг

дээр тулгуурлан, Степной ажилтнууд уг газрыг сүүлийн таван жилийн хугацаанд тогтвортой төллөж байгаа газар болон бусад үйл ажиллагаа явагдах байгалийн нөөцийн тогтвортой менежмент бүхий бүс нутаг гэж хоёр хэсэгт хуваан бүсчилсэн байна.

Төллөх улирлын дараах хаврын өдөр хоногуудад тэвчихийн аргагүй халуун болдог. Хавар ургамлан нөмрөг маргад шар өнгөтэй, хатуу гадаргуутай болж хувирна. Маш түгшүүртэй дүр зураг. Учир нь энэ үед байгалийн (жишээ нь, хуурайшлын үед аянгын улмаас) хүний нөлөөллөөс үүдэлтэй гал түймэр тохионо. Хээрийн өргөн уудам нутаг, болон тэнд амьдрагч бүх амьтдыг хамтад нь шатааж болно. Гал түймрийн улмаас учирсан хохирлыг багасгахын тулд, дархан газрын ажилтнууд



Степной дархан газар (баруун) болон Черные Земли нөөц газрын (зүүн) ажилтнууд жижиг галыг утрааж байгаа нь © IFAW

дархан газрын машин зам дээр ургасан ургамлыг цэвэрлэх, ургамлын нөмрөгийг багасгах зорилгоор нэн аюултай газрыг хагалж эхэлсэн. Эдгээр үйл ажиллагаа нь Астрахань бүс нутгийн Байгалийн нөөцийн газрын дэмжлэг, уугуул нутгаа, байгаль дэлхийгээ хайрлах дархан газрын ажилнуудтай тогтоосон фермерүүдийн олон талт харилцааны үндсэн дээр бий болж байгаа нь ойлгомжтой билээ.


2015 онд гал түймрийн аюултай үеийн эхэнд ОХУ-ын Амьтан хамгаалах олон улсын сан (IFAW) тусгай тоног төхөөрөмж худалдан авахад зориулж хөрөнгө (ус суваг татах болон өвс хадах машин гэх мэт) хуваарилсан. Энэ нь цагаа олж ирсэн бөгөөд мөн оны зургадугаар сарын 15-нд байгаль хамгаалах эргүүл, Степной дархан газартай хиллэх Черные Земли нөөц газраас гал түймэр ирж буйг удирдах газартаа мэдэгдсэн. Хоромхон зуур ямар ч эргэлзээгүйгээр, дархан газрын захирал Владимир Калмыков өөрсдийн хөршдөө туслахын тулд Черные Земли БНГ-ын бүх бартаат замын даацын машинуудыг маш хурдан тал руу очих түгшүүрийн дохиог өгсөн байна. Дархан газрын тогтвортой байгалийн менежмент бүхий бүсэд амьдарч байгаа фермерүүд мөн сайн дурынхантай нийлсэн нийлсэн байна. Аюулын дохио хүлээн авсанаас хойш нэг цагаас бага хугацаанд түймэр унтраах баг гал унтраахаар тэмцэж эхлэсэн.

Хүчтэй салхитай байсан учир 3 метр хүртэл өндөртэй галт хана бараг 20 км урттай

газарт замдаа таарсан бүхнийг залгисан. Энэ гэнэт дэгдсэн галын аюулд нэрвэгдэхэд хүрсэн Черные Земли нөөц газарт хамрагдах тээврийн хэрэгслүүдийг аварч чадсан байна. Гал түймэртэй тэмцэх ажил шөнө болтол үргэлжилсэн. Черные Земли нөөц газрын захирал Батаар Убушаевын тооцоолсоноор уг гал түймэрт түүний хариуцсан газрын 6000 га талбай нэрвэгджээ. Степной дархан газрын ажилтнууд галын бүсэд трактор болон анжисны тоог нэмэгдүүлсэн учир дархан газар руу орох галын тархалтыг хязгаарлаж чадсан.

Олон зүйл ургамал түймэрт нэрвэгдсэн. Маш их утаа болон шөнийн харанхуйд энэхүү шатсан газарт ямар нэгэн зүйл олж харахад хэцүү байсан бөгөөд зэрлэг ан амьтанд юу тохиолдсоныг хэлж чадах хэн ч байгаагүй. Тухайн үед тал хээрт амьдрах тогоруу, туулай, үнэг, хярс болон бусад дийлэнх амьтад ид төрж байсан бөгөөд тэдгээрийн олонх нь гал дундуур гарч чадаагүй.

Энэ нь тэр жил Черные Земли нөөц газарт гарсан эхний бөгөөд эцсийн түймэр биш байсан. Хиймэл дагуулын зургаас зургадугаар сарын хоёр дахь хагасаас хойш 2015 онд гал түймэр тогтмол гарч байсан болохыг харж болох бөгөөд нийт шатсан талбайн хэмжээ 100,000 га-д хүрсэн байна. Гэсэн хэдий ч, Степной дархан газрын ажилтнуудын хүчин чармайлтын үр дүнд тэдний хариуцсан газар гал түймэрт бараг өртөөгүй байна.



2015 оны зургадугаар сарын байдлаар түймэрт өртсөн нутаг (1 - Черные Земли Улсын Байгалийн Биосферийн Нөөц газар, 2- Астрахань бүс Степной ДЦГ)

Шинэ мэдээ (үргэлжлөл)

«Хамгааллын арлын найзууд» – хил хязгааргүй хөдөлгөөн

Евгения Самтанова¹, Наталья Шивалдова²

1 – Яшкульын олон салбарт дунд сургууль, ОХУ, Халимагийн БНУ, samtanova1957@yandex.ru;

2 – Узбекистан, «Эко мак таб» Экологийн нөөцийн төв, nshivaldova@mail.ru

«Байгаль хамгаалал арлуудын нөхөд» хөдөлгөөн нь ОХУ-д Байгалийн нөөц (дархан газар) газруудын Эко төвийн санаачилгаар 2000 онд эхэлсэн. Эхэн үедээ уг хөдөлгөөнд зөвхөн ОХУ-ын байгаль хамгаалах чиглэлээр ажилладаг гишүүд, дэмжигчид нэгдэж байв. Энэ жилийн хувьд уг хөдөлгөөн нь олон улсын түвшинд хүрсэн бөгөөд ингэснээр байгаль хамгаалах ажлыг хилээр хязгаарлаж болохгүйг харуулсан. 2015 оны 11 сарын 2-6 нд ОХУ-ын Байгалийн нөөц газар үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулан Олон улсын Залуучуудын Экологийн конгресс, «Байгаль хамгаалал арлууд найз нөхөд» хөдөлгөөн нь Воронеж хотод болов. ОХУ-ын 24 бүс нутгаас болон Азербайжан, Узбекистан, Казахстан, Беларус улсаас 150 гаруй төлөөлөгчид (хүүхдүүд, багш нар, дархан газрын ажилтнууд болон их, дээд сургуулийн оюутан) оролцжээ.

Олон улсын Залуучуудын Экологийн конгресст оролцсон Тал хээрийн зэрлэг амьтан хамгаалах клубийнхэн Бөхөн хамгаалал болоод байгаль хамгааллын сэдэвт хурлын үеэр маш идэвхтэй хамтран ажиллаж байв.

Халимаг, Узбекистанаас ирсэн Тал хээрийн зэрлэг ан амьтан хамгаалах клубийнхэн нэгдсэн баг болж ажилласан бөгөөд өөрсдийн байгаль орчныг хамгаалах төслөө амжилттай танилцуулсан. Тэд чуулганд оролцогчдыг анхаарлыг татсан бөхөн хамгаалах асуудлыг хөндсөн янз бүрийн техникийн болон бүтээлч хичээлийг зохион, бөхөнгийн амьдрах орчны хамгаалахад олон нийтэд хүрч ажиллах талаарх өөрсдийн туршлагаа хуваалцсан юм.

Чуулганд оролцогчид Казахстан дахь үл мэдэгдэх өвчний улмаас үүссэн бөөнөөр хиарсан явдал;



Хамгийн сайн экологийн төслийн шагнал хүлээн авсан Узбекистанаас ирсэн Тал хээрийн зэрлэг амьтан хамгаалах клубийн удирдагчид (© Д. Олдунова)

Казахстан, Узбекистаны хооронд барьсан хилийн тор, ОХУ-д гарсан хээрийн түймэр болон тархац нутгийн хүрээнд байгаа бүхий л улс орнуудад үргэлжилсээр байгаа хууль бус агнуурын нөлөөний талаар гэх мэт сүүлийн үед бөхөнд нөлөөлж буй эмгэнэлт үйл явдлын талаарх өөрийн санаа бодлыг харуулж байв.

Тал хээрийн зэрлэг ан амьтан хамгаалах клуб болон Бөхөн хамгаалах нийгэмлэгийн хамгааллын үр нөлөөг дэмжих сайжруулах талаар нийтээр хэлэлцэн чөлөөтэй санал бодлоо солилцох үед олон тооны асуултууд Зэрлэг амьтан хамгаалах клубийнхэнээс илтгэл тавигч нарт ирж байв. Эдгээр хэлэлцүүлгийн үр дүнд Орос, Узбекистан, Казахстан, Монгол болон Хятад, Европ болон АНУ-д бөхөнгийн нөөц газрын ойролцоох хотуудад уг хөдөлгөөнийг зохион байгуулж бөхөн хамгаалах хөдөлгөөнийг дэмжих санаа байв. Нүүдэллэдэг амьтад нь ямар ч хил хязгаарт баригдахгүй байна гэж онцлон, янз бүрийн улс оронд нэгэн зэрэг зохион байгуулах явдал юм. Ингэснээр бүх бөхөнгийн популяцид тулгарч ноцтой аюул заналд олон нийтийн анхаарлыг хандуулж чадах болно. Энэ талаар та юу гэж бодож байна вэ? Бид дэлхий даяар энэ санаачлагыг дэмжин ажиллахыг санал болгож байна!

Хамгааллын арлын найзууд конгрессийн дэлгэрэнгүй мэдээлэл

Конгрессийн нээлтийн ёслолын үйл ажиллагаа хурц тод, мартагдашгүй байсан бөгөөд янз бүрийн бүс нутгаас хүрэлцэн ирсэн багууд төлөөлүүлэн хамгаалах газраа билэгдсэн зураг бүхий тугийг бэлтгэсэн байв. Халимагаас ирсэн багийнхан Амьд өв хээрийн зэрлэг ан амьтан хамгаалах клуб болон Черные Земли нөөц газрын билэг тэмдэг болох нялх янзагыг өөрсдийн далбаан дээрээ байрлуулжээ. Конгрессын тангараг өргөх үеэр «Байгаль хамгаалах арлуудын төлөө» сүлд дууг гитарын аялгуунд хамгааллын арлууд хөдөлгөөний бүх далбааг зүйж хийсэн нэг том далбаа бүх оролцогчдын дээгүүр хийсэж байв.



Узбекистан, Халимагаас ирсэн оролцогчдод шилдэг экологийн төслийн шагнал гардуулж байна
(© Д. Олдурова)

Хамгаалах арлууд хөдөлгөөний нөхөд гишүүдийн 2013-15 онд явуулсан экологийн төслийн тэмцээний үр дүнг зарлах мөч уг хурлын хамгийн дурсгалтай, сэтгэл хөдөлгөм хэсэг нь байсан юм. Тал хээрийн зэрлэг ан амьтны клуб сүлжээг бий болгосон Узбекистаны Орос Евгения Самтанова, Узбекистаны Наталья Шивалдова нар тэмцээнд түрүүлсэн. Ялагч нарт диплом болон бага оврын нарны цахилгаан станц өгсөн байна.

Халимагийн Амьд өв хээрийн зэрлэг ан амьтан хамгаалах клубийг төлөөлж (Яшкул сургууль) Елзиат Манджиев, Тамараа Убушаева түүнчлэн Черные Земли Улсын Биосферийн нөөц газрын Экологийн боловсрол, Аялал жуулчлалын мэдээллийн хэлтсийн дарга Джиргала Олдурова нар байв. Узбекистаны багийг хамгийн үр дүнтэй ажиллаж байгаа клубууд болох Нукус хотын №37 ахлах сургуулийн Мадина Абдикаримова ахлагчтай «Надежда» клуб, Шашлик тосгоны №54 ахлах сургуулийн, Садырбай Шайменоваар



Халимагийн тал хээрийн зэрлэг амьтан хамгаалах клубийнхэн өөрсдийн удирдагч Евгения Самтановагийн хамт (© Н. Шивалдова)

ахлуулсан «Акбокен» гэсэн клубууд тус тус төлөөлж байв. Шүүгчид эдгээр улс орнуудын залуус, гайхалтай экологичдын хүчин чармайлтыг гайхан шагширч байв. Тал хээрийн зэрлэг ан амьтан хамгаалах клубийн гол уриа нь «Зэрлэг ан амьтдын хосгүй өв болох бөхөнг алдахаас урьдчилан сэргийлье» юм.

Концерт, ардын дискотек нь Конгрессийн сэтгэл санааны хөөрлийн үргэлжлэл байсан бөгөөд төлөөлөгч бүр өөр өөрсдийн өнгө төрх, хэв маягийг тусгасан бүжиг, дууг харуулж байна. Оролцогчид Елзиат, Тамараа нарын тоглосон «Мингбайр» нэртэй Халимаг ардын бүжгийг ихээхэн сонирхож байв.

Воронежийн Песков Улсын Шим мандлын нөөц газарт хийсэн аялал конгресст оролцогчдын хувьд тод томруун үйл явдал байсан. Маш сонирхолтой зүйл нь нөөц газрын мэдээллээр аялах болон түүний музей байв. Энэ албан



Конгресст оролцогчид бөхөнгийн баг зүүж байгаа нь
(© Н. Шивалдова)

ёсны бус экологийн форумын хаалтын ажиллагааг экологичдод дурсагдах бөгөөд үүгээр Конгрессийн үр дүнг нэгтгэн, ирэх жилүүдэд Тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа сайжруулах үндсэн чиглэлийн тухай тогтоол баталсан.

Төлөөлөгчид өндөр сэтгэгдэл, шинэ санаатайгаар Воронежийн зочломтгой нутгийг орхисон. Бид үнэхээр «байгаль орчныг хамгаалах арлуудын найзууд» болж, Конгрессоор батлан даасан өөрсдийн газар нутагаа нэр төртэй хайрлан хамгаалж, залуу экологичдийн шинэ үеийнхэнд байгаль хамгааллын сайхан зам эхлүүлэх болно гэж найдаж байна

Хэвлэлийн мэдээ



Якутад эртний бөхөнгийн гавлын яс олдлоо

ОХУ-ын Батаговын ойролцоох Улахан Сулларын Адыча голын эргээс 2015 оны 7 сард эртний бөхөнгийн гавлын яс олдсон байна. Гавлын ясны гарал үүсэл нь Хожуу Плейстоценийн үеийнх байсан бөгөөд тэр үед Якутад тал хээрийн трууутан амьтад болоод тундрийн зүйлүүд болох арктикийн үнэг, миксоген нар зэрэгцэн оршиж байсныг батална. Гавлын яс маш сайн хадгалагдсан бөгөөд эвэр, шүдний аль аль нь сайн байдалтай байсан, тиймээс цаашид судалгаа хийх боломж байна.

Дэлгэрэнгүйг дараах линкээс харна уу: http://ysia.ru/news/43865/v_yakutii_najden_cherep_drevnego_sajgaka.html

Кыргызстанаар дамжин Хятад руу явагдаж байгаа хууль бус бөхөнгийн эврийн худалдаа

2015 оны арваннэгдүгээр сард Шинжаан мужийн хилийн цагдаагийнхан дөрвөн хууль бус наймаа эрхлэгчдийг саатуулан, БНХАУ-ын «Торугарт» шалган нэвтрүүлэх боомт дээр 160 сая юанаар үнэлэгдэх 5300 бөхөнгийн эвэр болон бусад хууль бус барааг хураан авсан.

Саатуулагдсан ачааны машин Кыргызстанаас орж ирсэн. Тухайн улсад бөхөн байхгүйг харгалзан үзвэл эдгээр эврүүд Казахын бөхөнгийн эврүүд байх магадлалтай. Энэ нь Хятадад сүүлийн жилүүдэд хураагдсан хамгийн их хэмжээ бүхий бөхөнгийн эвэр юм. 2013 оны 9 сарын 5-нд Киргизстанаас Хятад руу оруулахыг завдсан 4470 бөхөнгийн эвэр хураан авсан мэдээ бий (БМ-17).

Дэлгэрэнгүйг дараах холбоосноос харна уу: <http://news.21cn.com/domestic/difang/a/2015/1105/13/30237697.shtml>.

Казахстанд бөхөнгийн хууль бус агнуур нь зохион байгуулалттай гэмт хэрэг болж байна

Казахстанд Хөдөө аж ахуйн яамны хэвлэлийн албанаас мэдээлсэнээс үзэхэд сүүлийн хоёр жилийн хугацаанд хууль бусаар ашиглах, худалдах, худалдан авах, хадгалах, тээвэрлэх, бөхөн алсан 139 эрүүгийн хэргийг шинээр бүртгэн нээсэн бөгөөд 90 эрүүгийн хэргийг шүүх эрх бүхий байгууллагад шилжүүлж, 126 гэмт хэрэгтэн шийтгэгдсэн байна.

Жишээлбэл: 2015 оны 4 сард Актобе мужийн Айтеке тосгонд 4 хууль бус анчин

41-ийг агнасан (<http://www.nur.kz/827741-v-stepyakh-aktyubinskoy-oblasti-brakon.html>); 2015 оны 10 сард Караганда мужийн Нура тосгонд 36 бөхөнгийн хөрөөдсөн эвэр, мах ачсан машин саатуулагдсан. Сүүлд, Актобе мужид 100 бөхөнгийн хөрөөдсөн эвэр ачсан 2 суудлын машин саатуулагдсан. http://bnews.kz/ru/news/obshchestvo/za_dva_goda_viyavleno_139_faktov_nezakonnoi_ohoti_na_saigakov-2015_10_27-1177953). 2015 оны 12 сард Кызылорда мужийн Кумкол Сырдарьягаас баруун зүгт 20 км-т Акши хэмээх газарт 5 гулууз, 1 толгой, 8 бөхөнгийн эвэр ачсан машин саатуулагджээ (<http://www.zakon.kz/4760643-zastrelivshie-5-sajgakov-brakonery.html>). Энэ бүх тохиолдол Бетпак-далагийн бөхөнгийн популяцийн тархац нутагт болсон байна.

ОХУ-ын иргэд хууль бус бөхөнгийн бизнест мөн оролцож байна. Кустанайд ОХУ-ын иргэн “хориглосон амьтан ургамлын зүйлүүд, тэдгээрийн гаралтай эд эрхтнийг хууль бусаар худалдаалахыг” завдсан учир шийтгэгджээ. 2015 оны 5 сард тэрээр хууль бусаар 82 бөхөнгийн эвэр худалдан авч, борлуулахаар Алмата хот руу зуучлагчаар дамжуулан илгээжээ. Цагдаагийнхан энэ хууль бус ачааг замд нь саатуулсан. (<http://informburo.kz/novosti/grazhdanina-rf-sudili-v-kostanae-za-nezakonnuyu-skupku-rogov-saygi.html>).

Бөхөн ОХУ-ын Улаанд номонд бүртгэгдэнэ

ОХУ дахь бөхөнгийн тоо маш бага билээ. Өнөөгийн байдлаар 4500-с илүүгүй тоотой байгаа бөгөөд буурсаар байна. Гэсэн хэдий ч бөхөнгийн хууль бус агнуур үргэлжилсээр байна. Он 2015 оны наймдугаар сарын 12-ны Черные Zemil нөөц газрын байцаагч нар Яшкул дүүргийн Тавн-Гашун тосгоны хогийн цэг дээрээс гурван бөхөнгийн арьс олжээ. Сүүлд Яшкул дүүргийн хоёр оршин суугчийн гэрээс 33 бөхөнгийн эвэр олж хураан авчээ. (<http://vkalmykii.com/rassleduetsya-delo-brakonerov>).

Баруун хойд пре-Каспийн бөхөнгийн популяцийн энэхүү ядмаг байдал нь ОХУ-ын Улаан номонд уг зүйлийг оруулах чухал шийдвэрт тусгалаа олсон байна. “Бөхөн нь аль хэдийнээ Халимаг, Оренбург болон Омск

зэрэг бүс нутгийн Улаан номонд орсон бөгөөд ОХУ-ын Улаан номонд оруулахыг санал болгож байна. Энэ нь хууль эрх зүйн журмын үйл явц дууссаны дараа ОХУ-ын Байгалийн нөөцийн яамнаас батлагдах болно» гэж Төрийн бодлого, журмын хэлтсийн байгаль орчныг хамгаалах газрын захирал Дмитрий Беланович Ташкент хотноо 2015 оны 10 сарын 26-29-нд болсон бөхөнг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглах харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурагч талуудын 3 дахь уулзалтанд оролцохдоо хэлсэн байна (дээрээс хар). Дэлгэрэнгүйг дараах линкээс харна уу: <http://www.mnr.gov.ru/news/detail.php?ID=14226>.

Өгүүлэл

Мониторинг судалгааны ач холбогдол: Бөхөнгийн хээрийн судалгааны түүх


Кристина Рысава Биологийн олон янз байдал, амьтны эрүүл ахуй, анагаах ухааны хүрээлэн, Грэйм Керр байр, Глазговын их сургууль, Глазгов G12 8QQ, Их британи, Kristyna.Rysava@glasgow.ac.uk

Казах хүмүүс бөхөн хаана үзэхийг мэднэ гэж хэлсэн хүнийг худалчид гэж ярилцдаг. Бөхөн олж харах нь хялбар биш! Эдгээр нүүдэлчин амьтан нь ямар ч газарт маш хурдан гүйдэг, жилийн шилжилт хөдөлгөөн нь 3500 км-аас их байдаг. Нүүдэллэх үедээ тэд цагт 70 км хурдтай, өдөрт 100 гаруй км аялах чадвартай. Ямар ч эргэлзээгүйгээр, тухайн байнгын нүүн шилждэг амьтдыг хайх нь бодит сорилт юм.

Гэсэн хэдий ч, бөхөнгийн мониторинг нь тэдгээрийг хамгаалах, менежмент, судалгааны


амжилтын гол хүчин зүйл юм. Сүүлийн хэдэн арван жилд хулгайн ан, амьдрах орчны доройтол, хүрээлэн буй орчны хэвийн байдал алдагдах, саяхан бөөнөөр хиарсан цуврал гамшигт өвчний дэгдэлт зэрэг олон аюул занал эдгээр амьтдад тохиож байна. Байгаль орчныг хамгаалагч нарт тулгарч буй бөхөнгийн популяци хэзээ, яагаад, хэрхэн өөрчлөгдөж буй зүй тогтлыг ойлгоход үр дүнтэй мониторинг судалгааны арга зүйг боловсруулах нь мэдээлэл болон үр дүнтэй оролцоог бий болгох боломжтой. GPS эсвэл радио телеметрийн хүзүүвчний аль нэгийг байрлуулах алсын зайнаас танин мэдэх аргачлал нь байнгын шилжилт хөдөлгөөнд оршдог зүйлийн мониторинг хийх нь нийтлэг арга юм. Цуглуулсан мэдээлэлд үндэслэн шилжилт хөдөлгөөн болон орон зайн тархалтын дэлгэрэнгүй мэдээлэл авч чадна. Эдгээр технологи нь хурдацтай хөгжин дэвшиж экологичид одоо хиймэл дагуул ашиглан илүү их мэдээлэл цуглуулах боломж бүрдсэн. Гэсэн хэдий ч, ойролцоо орших мах идэшт амьтдыг таньж тодорхойлох болон зан төрхийн бусад нарийвчилсан ажиглалт судалгаа хийхэд газрын мониторинг нь илүү тохиромжтой. Ялангуяа Төв Ази шиг хүрээлэн буй орчин хэцүү нөхцөлд газрын мониторингийг ашиглан бид ямар төрлийн мэдээлэл цуглуулж чадах, энэ бидэнд ямар ашигтай вэ?

Бөхөн өргөн уудам нутагт байршин амьдардаг хэдий ч тэдний тархан байршилт нь жилийн турш эрс өөрчлөгддөг. Хахир хатуу өвлийн нөхцлөөс хоргодох газар болох өмнө зүгийн хуурай цөлд өвлийг өнгөрөөсний дараа хаврын улиралд илүү идэш тэжээл сайтай газар нутгийг хайн буцаад хойшоо нүүдэллэдэг (Зураг 1i). Тэд буцах замдаа өвөл болон зуны бэлчээр нутгийн хооронд тавдугаар сард 2 долоо хоногийн хугацаанд төллөдөг. Төллөх үед махчдад илүү их өртөгддөг (Зураг 1ii). Тэд чонын үндсэн хоол тэжээл болох төдийгүй бүргэд, тас, үнэг зэрэг жижиг махчид нялх



Зураг 1 (i). Казахстаны бөхөнгийн гурван популяцийн 2008 оноос 2012 он хүртэлх улирлын тархац: Уралын (баруун хойд), Устыуртын (өмнөд төв) болон Бетпак-дала (хойд-төв нь хар зууван). Цэг бүр нь олон тооны бодгалиуд ажигласан нэг ажиглалтын цэгийг илтгэнэ. 5-9 сар хүртэл цуглуулсан цэгэн ажиглалтын мэдээлэлд үндэслэн тодорхойлсон зуны тархац нутгийг улаанаар, 12-3 сар хүртэлх мэдээлэлд тулгуурласан өвлийн байршил нутгийг цэнхэр өнгөөр үзүүлэв. Бүх популяциудын зун болон өвлийн байрши лнутагт өөр хоорондоо тодорхой хэмжээгээр хуваагдсан байгааг бид харж болно. Ихэнхдээ Бетпак-Далагийн зүүн хойд хэсэгт (улаан зууван дүрсээр онцолсон) популяцийн тодорхой хэсэг жилийн туршид тогтвортой байдаг ажээ.

Зураг 1 (ii). 2008-2012 оны 5 сард цуглуулсан ажиглалтын мэдээлэлд үндэслэн гаргасан үржлийн үеийн бөхөнгийн сүрэг болон мах идэшт амьтдын байршил. Төллөлт явагдаж буй нутгийн эргэн тойронд тохиолдсон хамгийн түгээмэл махчин нь саарал чоно тогтмол ажиглагдаж байжээ.



Зураг 2. Бөхөнгийн сүрэглэлтийн хамгийн бага, хамгийн их, дундаж хэмжээг (горим) сараар харуулсан байдал. Улаан шугамаар харуулсан сүргийн дундаж хэмжээ (2008 оны 4 сараас 2012 оны 12 сар хүртэл) мониторинг судалгааны хугацаанд бага юм шиг харагдана. Тэг утга бүхий сарууд нь мониторинг судалгаа хийгдээгүй илтгэнэ. 2009 оны 9 сараас 2010 оны 1 сар хүртэлх хугацаанд 15000 бодгаль бүхий сүргүүд тохиолдож байсан (хар өнгийн полигоноор харуулсан), эдгээр том сүргүүд 2010 оны 12 сар болон 2011 оны 1 сард мөн тохиолдсон. Төллөлтийн үеийнхтэй (5-р сар) харьцуулахад өвлийн саруудад бөхөнгийн нягтшил өндөр байсан нь өвөл харьцангуй их эндэгдэлтэй байсныг харуулж байна. Нөгөө талаар, хавар харьцангуй цөөн тоогоор бүртгэгдсэн нь олон тоотой сүрэглэсэн амьтдыг тоолоход гарах хүндрэл, бэрхшээлээс шалтгаалан төллөлтийн үеийн тооцооллыг буруу гаргасан байж магадгүй юм.

төлийг барьж иддэг. Бөхөнг ажиглах нь зөвхөн улирлын болон орон зайн тархалтын мэдээлэл өгөх төдийгүй зан авир, сүргийн доторх онцлогийн талаарх мэдээллийг цуглуулж чадна. Жишээ нь, бид бөхөн нь тогтмол шилжин нүүдэллэдэг гэж бодож байхад, Бетпак-далагийн популяцийн баруун хойд хэсэгт жижиг алслагдсан сүрэг жилийн турш тогтвортой байршдаг байна (Зураг 1i). Олон тууртан амьтдын хувьд ойролцоо нөхцлөөс хамааран нүүдлийн болон суурин гэсэн хоёр амьдралын хэв маягийн аль алинийг ашиглах нь ховор үзэгдэл биш юм (жишээ нь: тайгын амьтад, цагаан сүүлт буга)

Бөхөн цөөнөөрөө эсвэл олон тоогоор сүрэглэн амьдардаг амьтад. Сүргийн дундаж хэмжээ улирлаас хамааран эрс өөрчлөгдөх бөгөөд нэг сүрэгт 10-1000 хүртэл бодгаль байдаг. Хамгийн гол нь төллөх, нүүдэллэх болон орооны үед бөхөн бөөгнөрөн том сүрэг үүсгэх хандлагатай байдаг; сүрэглэн амьдрагч амьтад нийгэмч зан төрхийн ашиг тус ихээхэн байдаг. Сүрэглэх нь махчдын эсрэг тэмцэх томоохон хамгаалалт болж өгдөг. Том, өнөр сүргийн хэлбэр нь мах идэшт амьтдын нөлөөнд ямар нэгэн


хамгаалалтгүй янзага эмзэг байх үржлийн улиралд ихээхэн чухал юм. Өмнөх судалгааны дүн (Милнер-Гулланд, 2001) тоо толгойн бууралтын улмаас бөхөн томоохон хэмжээний төллөлтийн үеийн сүрэг үүсгэж чадахгүй байгаа нь махчдад өртөх эрсдлийг нэмэгдүүлж, янзаганы үхэл хорогдол ихэсхэд нөлөөлж байгааг харуулна. 2009-2011 онд өвлийн саруудаас илүүтэйгээр тавдугаар сард буюу төллөлтийн үед бөхөн харьцангуй цөөн тоогоор сүрэглэсэн нь бүртгэгджээ (Зураг 2).

Сүрэглэлтийн ач холбогдол нь хоёрдмол утгагүй байх боловч, популяцийн динамик дахь нас хүйсний бүтцийн нөлөөг одооноос илүү их ойлгож эхэлж байна. Эрэгчнээ алдах нь бөхөнд тулгамдсан аюул гэж харагдахгүй байна. Олон эмэгчин хураадаг амьдралын хэлбэртэй зүйлийн хувьд ороо хөөцөөний үед эрэгчин нь 2-15 шаргачинг хурааж, хээлтүүлэх бөгөөд өрсөлдөгч нараас хамгаалан тэмцдэг. Тиймээс цөөхөн эрэгчинтэй байх нь том асуудал мөн үү, биш үү?

Эвэр болон арьсыг ашиглах зорилгоор эрэгчин амьтанг сонгон агнах нь Халимагийн популяцийн хүйсний харьцааг алдагдуулж байгаа бөгөөд хамгийн аюултай нь 100 эмэгчинд нэг эрэгчин ноогдож байна (Милнер-Гулланд нар., 2003). Бие гүйцсэн эрэгчний тоо хангалтгүй байгаа нь популяцийн тоо толгой буурахад хүргэсэн. Сүргийн нөхөн үржихүйд ихээхэн хувь нэмэр оруулдаг бие гүйцсэн эрэгчин байхгүй болж тоо толгой багасаж, амжилттай үржих чадвар хомс, туршлагагүй залуу эрэгчингүүд тохиолдож байна.

Энэ судалгаанд КБТЗХН-ийнхэний хийсэн хээрийн ажиглалтын мэдээ болон 2008-12 онд Казахстаны бөхөнгийн байдал, чиг хандлагыг судлах зорилгоор зохиогчийн боловсруулсан мэдээллийг харуулж байна. Төрийн байгууллагын байгаль хамгаалагчид болон КБТЗХН-ийн ажилтнууд оролцсон хээрийн мониторинг болон мэдээ цуглуулах ажилд нийт 45 ажиглагч оролцсон. Халимагийн бөхөнгийн популяцитай харьцуулахад харьцангуй том, тогтвортой популяци болох Казахстаны бөхөнгийн популяцид 2008-2012 оны хооронд нас хүйснээс хамаарах нөхөн үржихүйн ямар нэгэн уналт ажиглагдаагүй

Өгүүлэл (үргэлжлэл)




Зураг 3. 2008-2012 оны хооронд гүйцэтгэсэн хээрийн мониторингт үндэслэн тодорхойлсон Казахстаны бөхөнгийн хүйсний харьцаа. Бүтэн жилийн (i) болон ороо хөөцөөний үед (12 сар) цуглуулсан ажиглалтын мэдээлэл (ii) энэ хугацаанд өмнө нь Халимагт бүртгэгдсэн шиг эмэгчин рүү хазайсан алдаа (1 эрэгчинд 20-с дээш эмэгчин) Казахстанд гараагүй. 2011 оны ороо хөөцөөний үед буюу 12 сард мониторинг судалгаа хийгээгүй.

(Зураг 3). Нас болоод хүйсний харьцааны талаарх мэдээллийг шууд ажиглалтаар цуглуулахад хялбар хэдий ч маш болгоомжтой хандах ёстой (Зураг 3, 4). Амьтдыг хамтдаа байхад, хэт хол зайнаас залуу бодгалийг бие гүйцсэн амьтдаас ялган таньж болох ч эсрэгээр эвэр нь бүрэн ургаагүй, бэлэг боловсроогүй залуу бодгаль эмэгчинтэй адил харагдана. Эдгээр нь тодорхой бус тул шууд дүгнэлт хийх хүндрэлтэй байдаг.

Бөхөнг олж харах нь үнэхээр ур чадвар шаардана! Байгаль цаг уурын хүнд нөхцөл болон хязгаарлагдмал санхүүгийн болон хүний нөөцтэйгээр Казахстанд бөхөнгийн мониторинг судалгаа хийх нь ихээхэн хүндрэлтэй асуудал юм. Газрын мониторинг судалгаанаас бүрдсэн мэдээллийн хамрах хүрээ болон уялдаа холбоо бага байгаа нь улирал, хээрийн нөхцөлтэй нийцүүлэн тодорхой бус, зайлшгүй гарах алдаа зэрэг нь популяцийн хандлагын

цаад механизмын дүн шинжилгээ хийх ажил хязгаарлагдмал хэвээр байна. Гэсэн хэдий ч хээрийн судалгаа нь ландшафтын өөрчлөлтийн нөлөө зэрэг асуудлууд болон популяцийн хандлага, амьтны зан авир зэрэг үнэ цэнэтэй ажиглалтын мэдээллийг үзүүлж байдгаараа орлуулашгүй юм. Стратегийн үр өгөөжтэй арга хэмжээг бий болгохын тулд асар өргөн уудам газар нутгийг хамруулахаас эхлээд чухал үүрэгтэй дамжин нүүдэллэдэг нутагт мониторинг судалгаа хийснээр байгаль хамгаалагчид аюул заналыг тодорхойлох, нөлөөллийг багасгахад зорилгоор түргэн шуурхай ажиллах чадвартай байх ёстой. Хээрийн мониторинг судалгаа нь ямар ч эргэлзээгүйгээр сайжруулах боломж бүхий бодит цаг хугацаанд менежмент хэрэгжүүлэх үр ашигтай арга хэрэгсэл болно. Гэхдээ судалгааны хөтөлбөр нь төсөв мөнгөний хязгаарлагдмал байдлын улмаас зогсонги байдалд орж болох учраас ихэнх тохиолдолд мэдээлэл цуглуулах арга техникийг сайжруулах ажлыг урт хугацааны чухал мэдээллийн багц үүсэхээс өмнө хэрэгжүүлэх ёстой. Харин үүний оронд судалгааны хөтөлбөр нь илүү үр дүнтэй мониторинг судалгааг бий болгон, тэдгээрээс үүсэн бий болох мэдээллийн үнэ цэнийг үнэлэх шаардлагатай. Бид хир их том зүйлийг харж чадах тусам түүнийг хэрэгжүүлэх арга зам үргэлж байх болно.



Зураг 4. 2008-2012 оны мэдээлэлд үндэслэсэн бөхөнгийн популяцийн насны бүрдэл. Олон бодгалийг таньж тодорхойлж чадаагүй (саарал). Хол зайнаас бөхөнгийн хүйс, насны ангиллыг нарийн ялган гаргах нь хялбар биш. Иймээс энд болон зураг 3-т үзүүлсэн мэдээлэлд болгоомжтой хандах хэрэгтэй.

Астрахан мужийн Степной ДЦГ-ын бөхөнд гүний худгийн үзүүлэх нөлөө

Андрей Гилев & Кристина Каренина. Сээр нуруутан амьтан судлалын тэнхим, Санкт Петербург их сургууль, ОХУ, zoology.gilev@gmail.com, angil_1305@mail.ru



Артезийн нуурын ойролцоох задгай газарт өрнөж буй залуу эрэгчнүүдийн өрсөлдөөн. (© А. Гилёв., К. Каренина)

Бөхөнгийн амьдралд гүний худаг болон үерийн ус зэрэг өөр өөр усны эх үүсвэрийн гүйцэтгэх үүрэг маш сайн мэдэгдэж байна. Уг зүйлийн хамгийн эмзэг үе болох төллөлтийн үед болон зуны нарны хүчтэй гэрэлд ногоон ургамал хатаж эхэлсэнээр нялх төл бодгалиудад ихээхэн чухал үүрэгтэй. Бид Астрахан мужийн Степной дархан газрын 2015 оны 5 сарын 11-30-ны ажиглалт хийн, бөхөнд гүний худаг хэрхэн нөлөөлж байгааг судалсан. Бид гүний худгаас хальж үүссэн жижиг нуурын ойролцоо түр ажиглалт хийх нуувч барьсан. Энэ нь бүх тал руу харах боломжтой ажиглалтын цооног бүхий жижиг, өнгөлөн далдлах өнгөтэй майхан байсан. Ажиглалтыг өдөр бүр 3:00-11:30 болон 17:00-19:30 цагийн хооронд хийв. Хоёр ажиглагчид нуувчинд байж, зөвхөн ямар ч бөхөн харагдахгүй нөхцөлд байршлаа орхиж байсан. Мониторинг судалгаанд дуран, гэрэл зургин болон видео камер ашигласан. Амьтдыг хажуу талаас, бүтнээр, нүүрэн хэсгээс зураг

авч, дараа нь онцгой өнгө, шарх сорви, толгойн халзралт, бусад төрөлхийн шинж тэмдэгүүдийг бодгаль амьтдыг тодорхойлоход ашигласан. Эврийн нөсөөжилт болон эврийн суурины хэлбэр, цагираг хоорондын байршил нь эрэгчин амьтдын хувьд чухал ач холбогдолтой тэдгээрийг ялгах шинж тэмдэг болдог. Хэрвээ тухайн амьтанд тодорхой шинж тэмдэг (сорви, өнгө хэв маяг) байхгүй бол, эмэгчин амьтдыг тэдгээрийн духан дээр бараан өнгийн үсний ялгааг ашиглан тодорхойлсон.

Ажиглалт хийсэн 20 хоногийн хугацаанд усанд орж ирэх бөхөнгийн тоо өдөр бүр харилцан адилгүй байсан. Өдрийн агаарын температур +17-+35°C, дунджаар +25°C байв (Лиман тосгоны www.gismeteo.ru сайтаас авсан мэдээллээр). Өдөрт ойролцоогоор 51-1569 бөхөн (дундаж 466 ± 119) артезийн гаралтай нуур орчимд тэмдэглэгдсэн байна. Хамгийн олон тоотой амьтад 5 сарын 23, 25,

Өгүүлэл (үргэлжлэл)



Артезийн нуураас ус ууж буй залуу бөхөнгүүд .
(© А. Гилёв., К. Каренина)

26-нд тэмдэглэгдсэн (ойролцоогоор 1569, 923 болон 1094 бөхөн). Ажиглалтыг зөвхөн өдрийн тодорхой цаг хугацаанд хийсэн тул артезийн гаралтай нууранд ирэх бөхөнгийн бодит тоо арай их байж болох юм. Тухайн бодгаль бүрийг таньж тодорхойлсоноор олон амьтад (хамгийн их нь 12 өдөрт 18 удаа тэмдэглэгдсэн) усанд дахин дахин ирж байгааг харуулж байна. Энэ нь Степной нөөц газрын доторх бөхөнгийн популяцийн оршин байхад артезийн гаралтай нуур ач холбогдолтойг харуулна.

Артезийн гаралтай нуур ус болон эрдэс бодисын эх сурвалж болох нь

Нийтдээ 195 цаг үргэлжилсэн бидний ажиглалтын явцад бөхөн артезийн гаралтай нууранд ойртон ирсэний дараагаар ус ууж эхлэх юмуу эсвэл эргийн нүцгэн хөрсийг долоож байсан. Зарим амьтад нь ус руу ирэхгүй байсан хэдий ч бараг амьтан бүр эргийн хөрсийг долоох, идэхэд (40 минут хүртэл) багагүй урт хугацаа зарцуулсан. Энэ нь хоол боловсруулах замын бичил биетнийг тогтворжуулах болон хорт бодисыг саармагжуулах байгалийн шингээгч төдийгүй эрдэс бодисын эх сурвалж болох шаварлаг хөрсийг олон шувууд, хөхтөн амьтад иддэг үндсэн онцлог юм. Тиймээс, артезийн ус нь зөвхөн тэдгээрийг ус уух газар болоод зогсохгүй эрдэс бодисын дутагдлыг хангахад чухал үүрэгтэй. Төллөлтийн үед эрдэс бодисоор баялаг хөрсийг идэх нь хээлтэй

эмэгчинд чухал ач холбогдолтой бөгөөд төллөлт эхлэснээс хойш олон тооны хээлтэй шаргачин нууранд ирж, хөрс идэхэд ихэнх цагаа зарцуулах болсон. Бодгалиар нь таньж тодорхойлсон эмэгчин амьтад артезийн нуурын ойролцоо 12 өдрийн турш (төрөхөөс өмнө болон төрсөний дараах) байж хөрс идэж байсан. Ганц нэгээрээ яваа болон эрэгчин эмэгчний холимог сүрэг, эсвэл дан эрэгчний сүрэг мөн л ус уухаар эсвэл хөрс идэхээр нуур руу тогтмол ирж байсан. Төл бүхий шаргачингууд хөрс идэхэд дийлэнх цагаа зарцуулж байв. Урт удаан хугацаанд, ихэнх тохиолдолд нялх янзага нь зөвхөн сүү удаг гэсэн одоогийн баримт нотолгоо байдаг (Зураг 2) хэдий ч эсрэгээр нялх янзага (6-8 хоногтой ба түүнээс дээш) эхтэйгээ хамт байхдаа эсвэл ганцаараа байсан ч хөрсийг долоохыг оролдоогүй байна.

Нийгэмших болон амрахад артезийн нуурын холбогдол

Артезийн нуурын орчимд байх томоохон ургамал ургаагүй газар нь бөхөнгийн хувьд нийгмийн харилцаанд идэвхитэй орох газар байсан. Энэхүү харилцаа холбооны нийтлэг хэлбэр нь залуу эрэгчингүүдийн хоорондох өрсөлдөөн байв. Эдгээр нь маш богинохон хугацаан өрнөж байсан ба ихэвчлэн хөрс идэж буй амьтдын аль нэг нь эсвэл хоёулаа хоорондоо өрсөлдөж, тухайн газарт хамтрагч амьтдын байнга өөрчлөлтөөр тодорхойлогдож байв. Эрэгчин амьтад бие биенийгээ шархдуулаагүй. Энэхүү өрсөлдөөн тэмцэлдээний хэлбэр нь ороо хөөцөөний үед амжилт гаргахад хэрэгтэй болох нь харваас илт ажиглагдана. Нас бие гүйцсэн эрэгчингүүд ус уухаар эмэгчний сүргээ туун ирж буй эрэгчинг хөөн тэдгээрийн эмэгчинг хураан авч байсан. Хэрвээ сүрэгт нэгээс илүү эрэгчин амьтад байвал тэд хоорондоо байнга тэмцэлдэнэ. Тэдгээрийн хоорондох өрсөлдөөн залуу бодгалийн хооронд болдогоос илүү их хүчтэй, ширүүн өрнөдөг. Гэсэн хэдий ч ямар ч тохиолдолд амьтад бие биэндээ ил харагдах шарх сорви үлдээдэггүй.

Артезийн нуурын ойролцоох нүцгэн газарт эмэгчин бөхөнгүүд бие биетэйгээ нийгмийн харилцаанд орох хэдий ч эрэгчнийг бодвол

харьцангуй бага хэмжээтэй байна. Ховор тохиолдолд эмэгчин амьтад өөрсдийн хөрс идэж буй газрын ойролцоо байх бусад амьтдаа хөөх, мөргөх зан авир гаргаж байв. Зарим тохиолдолд санаачлагч нь бусад эмэгчнээ 20-40 секунд хөөнө. Цаг хугацаа өнгөрөх тусам эмэгчин бөхөнгүүд бие биедээ найрсаг зан төрх үзүүлж, хошуугаар нөгөө эмэгчнийхээ толгойг маажиж эхэлдэг. Энэ харилцаа артезийн нууранд хамт ирсэн хоёр эмэгчний хооронд үүсэж байв.

Янзагатай эмэгчингүүд ирэхэд янзаганууд үргэлж хамтдаа тоглоно. Ихэр янзаганууд илүүтэйгээр хамт тоглох боловч зарим тохиолдолд өөр өөр эмэгчний янзагатай түр хугацаанд хамт тоглоно. Нэмж хэлэхэд нялх янзаганууд эрэгчин болоод бусад бие гүйцсэн амьтадтай нийгмийн харилцаанд тогтмол орж байв. Иймээс артезийн нуурын ойролцоох газар нутаг нь залуу амьтдын хувьд нийгэмших аюулгүй газар болно. Эхийнхээ нүдэнд сайн харагдах газар хүртэл янзага нь эхээсээ холдон явах хэдий ч байнга харуулдсаар байдаг. Бусад амьтадтай идэвхтэй харилцаанд орох нь ямар ч эргэлзээгүйгээр янзаганы нийгэмших

чадварыг бий болгоход чухал ач холбогдолтой юм. Ер нь, артезийн нуур орчимд нийгмийн харилцаанд орох онцгой нөхцөл нь популяцийн амьдрах чадварыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах болно.

Артезийн нуур нь бөхөнгийн хувьд амрах газар болно. Эрэгчин, эмэгчин бөхөнгүүдийн аль аль нь үе үе нуурын эрэг дээр хэвтэн, нүдээ анин амрах боловч толгой өргөөстэй хэвээр байна. Эмэгчин амьтад нь ихэвчлэн 5-10 амьтан бүхий жижиг бүлгийн хэлбэрээр амарч байна. Бие гүйцсэн эрэгчигүүд нь эмэгчнээ хураах, бусад эрэгчинтэй өрсөлдөх хоёрын хоорондох хэдхэн секундын хугацаанд хэвтэн амарч байв. Артезийн нуурын эргэн тойронд нээлттэй орон зай сайн харагдах тул амрах газар нь аюулгүй орчныг хангаж байна гэсэн үг юм.

Зохиогчид энэ судалгаанд болон бөхөн хамгаалалд үнэлж баршгүй хувь нэмэр оруулж буй Степной дархан газрын захирал Владимир Калмыкий болон Степной ДЦГ-ын ажилтнуудад талархсанаа илэрхийлж байна. Энэ ажлыг ОХУ-ын суурь судалгааны сангийн тэтгэлгээр хийсэн (грант №14-04-31390).

Узбекийн Устюртийн өндөрлөг дэхь бөхөнг хууль бусаар ашиглахад хүргэж буй хүчин зүйлийг ойлгох нь

Лаура Кор¹, Мария Грицына², Елена Быкова², Карлин Сэмуэл³, Э.Дж. Милнер-Гулланд¹

1 Их Британи, Лондонгийн Эзэн хааны коллеж. 2Узбекстан, Амьтан, ургамлын генийн нөөцийн хүрээлэн. 3Бөхөн хамгаалах нийгэмлэг. 4. Их британи, Оксфордын их сургууль. Холбогдох зохиогч: Лаура Кор, laurabkor@gmail.com

Оршил

Устюртын бөхөнгийн популяцийн тархац нутгийн хүрээнд явагдаж буй дэд бүтцийн хөгжил, хууль бус ан агнуурын үйл ажиллагааны улмаас бөхөнгийн тоо толгой улам бүр буурсаар байгаа билээ. Казахстан, Узбекистан хооронд босгосон хилийн хашаа нь нүүдлийн замыг маш ихээр хаасан бөгөөд Узбект үлдсэн бөхөнгийн популяцийг хамгаалах зорилгоор хууль бус ан агнуурын дарамтыг шийдвэрлэх шаардлага гарч байна. Энэхүү судалгаанд хүний шийдвэр гаргах үйл явцыг судалдаг нийгмийн сэтгэл зүйн орчны хүрээнд Төлөвлөсөн ёс зүйн онолыг (TPB) ашигласан (Бөхөнгийн мэдээ 19, Mabbutt

нарын өгүүллээс үзнэ үү). Бид бөхөнгийн мах идэх болон тэдгээр амьтдын хамгаалал, хулгайн анд хандах хүмүүсийн хандлагыг ойлгохыг зорьсон.

Арга зүй

Судлаачид 2015 оны 5 болон 6 сард Узбекстанд айл өрхийн тоон асуулга болон мэдээлэгч (ГИ) нартай ярилцлага хийсэн. Айл өрхөөс авсан аман асуулгыг Төвлөрсөн ёс зүйн онолд заагдсан 3 тодорхойлох шинжүүр болох хандлага, нийгмийн хэм хэмжээ, ухамсартай зан үйлийн хяналтаар шалгасан. Бөхөнгийн тухай мэдлэгийг нэмэлтээр үнэлсэн. Гол мэдээлэгч нараас авсан ярилцлага нь

Өгүүлэл (үргэлжлөл)



ШУА дээр гол мэдээлэгч нараас асуулга авч байгаа нь. (© А.Есипов)

мэргэжлийн мэдлэг бүхий асуулга судалгаанд оролцогчдын ойлголтыг таньж мэдэх илүү уян хатан байдлаар төлөвлөсөн. Нэг зуун дөрвөн өрхийн асуулга судалгааг Кырк-Кызын Кубла Устюрт, Устюртын тосгонд авсан бол мөн адил тосгод болон Нукус, Ташкент зэрэг хотоос 15 гол мэдээлэгч нартай ярилцлага хийсэн. Бөхөнгийн хэрэглээ, хулгайн анг тойрсон хэлэлцүүлэг маш эмзэг байдалтай байсан бөгөөд судалгаанд оролцогчдын 31% нь хариу хэлэхээс татгалзсан.


Үр дүн

Бөхөнгийн махны худалдаанд гарсан өөрчлөлт

Манай оролцогчид бөхөнгийн махны хэрэглээ, худалдан авах түвшин өмнөх жилүүдийнхээс хамаагүй багассан бөгөөд энэ нь бөхөнгийн тоо толгойн бууралттай холбоотой биш, харин хууль эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт болон мэдлэг өргөжсөнтэй холбоотой гэж үзсэн. Мах худалдан авч хэрэглэж байгаа хүмүүсийн эдийн засгийн байдал мөн өөрчлөгдсөн байна. Бөхөн мах “маш муу мах” бөгөөд зөвхөн ядуу хүмүүс үүнийг иддэг хэмээх үзэл бодолтой хүмүүс оролцогчдын дөнгөж 13%-ийг эзэлж байна. Харин эсрэгээр, баян чинээлэг, хот суурин газрын хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнээс үүдэн хулгайн анчид нэмэгдсэн байна. Байгаль хамгаалагчийн эргүүл шалтгалт, бөхөнгийн байршлын мэдээллийг хулгайн анчдад өгөх зэргээр бөхөнгийн хууль бус агнуурт хоньчдын үүрэг их болох нь илэрч байна.

Мэдлэгийн ач тус

Мэдлэг нь бөхөнд хандах хандлагатай эерэг хамааралтай байсан бөгөөд бөхөнгийн экологи, хууль тогтоомжийн талаар дэлгэрэнгүй мэдэж байсан хүмүүс бөхөнгийн тухай эерэг



хандлагатай байсан (Спеарманы шалгуур; $rs=0.434$, $p<0.01$). Мэдлэгийн оноо нь нас, хүйс, тосгон, ажил эрхлэлтийн байдлаар харилцан адилгүй байсан хэдий ч бөхөнгийн мах хэрэглэх нь хууль бус явдал гэдгийг хүлээн зөвшөөрсөн судалгаанд оролцогчид ердөө 34% нь маш бага хэмжээ юм. Бөхөнгийн мах хэрэглэх нь хууль бус зүйл гэдгийг мэдэхгүй хүмүүс үүнийг хэрэглэх нь хэвийн зүйл гэж үзсэн хүмүүсээс илүү их байсан (T-test; $t=2.21$, $df=99$, $p=0.03$). Бөхөн хамгаалах нийгэмлэгээс хийж буй сурталчилгааны ажил олон нийтэд хүрсэн нь маш бага буюу нийт асуулгад оролцогчдын 26% нь Бөхөн хамгаалах өдрийн тухай сонссон бол тэдгээрийн ердөө 11% нь Тал хээрийн зэрлэг амьтан хамгаалах клубийн талаарх мэдээлэлтэй байв. Үүний шалтгаан нь хүн ам ихээр суурьшдаг, хууль бус ан хийгчид олон

тоогоор байх Жаслык болон Каракалпакиа тосгодтой харьцуулахад дээрх тосгодод Бөхөн хамгаалах нийгэмлэгийн хамгааллын үйл ажиллагаа харьцангуй сул хэрэгждэгтэй холбоотой. Нийтдээ асуулгад хамрагдсан 101 хүнээс 8 нь өмнө нь Бөхөн хамгаалах өдөрт оролцож байсан байна.

Зан авирын шалгуурууд

Хүмүүс бөхөнгийн мах идэх талаар эерэг байр суурьтай байсан боловч энэ нь бодит хэрэглээг авч үзэхэд маш бага хэрэгжилттэй байсан (Зураг 1). Тиймээс, олон нийтийн нийт чиг хандлагын талаар анхаарлаа хандуулж ажиллахаас илүүтэйгээр бөхөнгийн хууль бус ан агнуур хийхэд хүргэж буй асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Дүгнэлт, санал зөвлөмж

Цаашид Устюртын бөхөнг хамгаалах санаачлагуудыг зорилтот бүлэгтэй холбогдуулан дараах үйл ажиллагааг тусгах ёстойг онцолж байна:

- Ан агнуураас хамаарах хамаарлыг бууруулахад анхаарч, Устюртын тосгодод шаардлагатай махны сонголт, олдоц, эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэх
- Энэхүү хамгааллын санаачлагад бөхөн махны худалдаалах гол эх сурвалж болж буй Нукус зэрэг хот суурин газрын баян чинээлэг хэрэглэгчид хамрагдах ёстой. Тэдгээрийн оролцоог тодорхойлох, хандлагыг өөрчлөх хамгийн сайн арга хэрэгслийг судлан мэдэх шаардлагатай.
- Хоньчид хууль бус анг дэмждэг нь тодорхой болсон. Байгаль орчныг хамгаалах ажилд оролцуулах зорилтот бүлэг болгож болох бөгөөд жишээлбэл зэрлэг ан амьтдын хяналтын судалгаанд тэдгээрийг оролцуулж болно гэдгийг харуулж байна.
- Бөхөн болон бусад зэрлэг амьтдыг тойрсон орон нутгийн иргэдийн мэдлэгийг дээшлүүлэхэд хүчин чармайлт гарган үргэлжлүүлэн ажиллах ёстой. Бөхөн хамгаалах нийгэмлэгийн үйл ажиллагаа нь илүү өндөр түвшинд байх хэрэгтэй.
- Бөхөнгийн мах идэх нь орон нутгийн иргэдийн уламжлалт соёлын нэг хэсэг гэж үздэгт анхаарал хандуулан цаашдын ан агнуур, хэрэглээг хангах арга хэрэгсэл болгон ашиглаж, бөхөн хамгааллыг дэмжих ашигтай байж болох юм.
- Казах-Узбекийн хилийн хашаа популяцийн тоо толгойн бууралтын гол шалтгаан болж байгаа бөгөөд сөрөг нөлөөллийг бууруулахад олон улсын хамтын ажиллагаа шаардлагатай.

Энэ ажлыг дэмжиж ажилласан Disney хамгаалах сан баярлалаа. Энэ судалгааны бүрэн гүйцэд мэдээллийг доорхи линкээр авч болно: <http://www.iccs.org.uk/wp-content/uploads/2015/11/MSc-Thesis-LKor.pdf>

Өгүүлэл (үргэлжлэл)

Өсвөр насныханы мөрөөдөл: Казахстанд шинэ хамгааллын санаачлагад өсвөр насныханы хүсэл эрмэлзлийг яаж ашиглаж болох вэ?

Софи Эллиот¹, Жанна Аксартова², Карлин Сэмүэл³, Э.Дж. Милнер-Гулланд^{1,3}

1. Лондонгийн Эзэн хааны коллеж, floatingteabags@yahoo.co.uk. 2. Казахстаны Биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг. 3. Бөхөн хамгаалах нийгэмлэг ба Оксфордын их сургууль / Автор-корреспондент: Холбогдох зохиогч: Э.Дж. Милнер-Гулланд ej.milner-gulland@zoo.ox.ac.uk



Бөхөн хамгаалах өдөр авсан шагналдаа баярлаж хөөрсөн Ашибай сургуулийн хүүхдүүд © Софи Эллиот

Энэхүү судалгаагаар Казахстанд өсвөр насныханы эрхэмлэн үзэж нийгмийн үйл ажиллагаа болон хүсэл эрмэлзлийг тодорхойлох, бөхөн хамгааллын талаар өнөө үед хийгдэж буй хамгааллын санаачлагад тэднийг хэрхэн илүү сайн оролцуулж болохыг тодорхойлохыг оролдсон. 2014 оны 5-8 сард Казахстаны Уралын бүс нутгийн Ашибай, Нурсай хоёр тосгоны 56 өсвөр насныханаас авсан асуулга судалгааг гүйцэтгэсэн, Их Британи, Орос, Казахстан, Узбекистан болон Монгол Улсын зургаан залуу судлаачдаас асуулга авсан.

Казах тосгодын өсвөр насныханы хамгийн их хүсэж буй мэргэжил нь багш, эмч, архитектор/ загвар зохион бүтээгч, байгаль орчныг хамгаалах ажилтан, дуучин байсан. Тэдний хүсэл эрмэлзлийг ирээдүйн карьерийн таамаглалтай харьцуулан үзэхэд хамгийн их тохирсон ажлын байр нь дуучин, архитектор / загвар зохион бүтээгч, зураач/, зураач, үсчин, албаны ажилтан, спортын тамирчин, байгаль хамгаалагч байсан (Зураг 1). Цөөн тооны өсвөр насныхан багш болохыг хүсдэг боловч энэ хариулт нь маш түгээмэл байв.

Өсвөр насныхан мөрөөдлийн ажлаа хийхэд юу саад болж болох талаар өөрсдийн үзэл бодлоо илэрхийлсэн бөгөөд хамгийн олон давтагдсан шалтгаан нь боловсрол, шалгалтын үр дүн (өсвөр насныханы 25%), мөнгө, санхүүгийн шалтгаан (судалгаанд оролцсон өсвөр насныханы 21%) гэж үзсэн байна. 14 хүнээс 13 нь боловсрол, шалгалтын үр дүн нь тухайлбал эмч, компьютерийн программист, эсвэл архитектор зэрэг дээд боловсрол шаарддаг ажилтай болоход нөлөөлнө гэж үзжээ.

Эдгээр мөрөөдлийн ажлын байранд хүрэхийн тулд дээд боловсрол эзэмших нь мөнгө, санхүүгийн саад бэрхшээлтэй холбож буйг өсвөр насныханы судалгаа харуулж байна.

Өсвөр үеийнхний хүсэл мөрөөдөл, ирээдүйн карьерын таамаглалыг тэдний тэдний эцэг, эхийн ажил эрхлэлтийн байдалтай харьцуулан үзэхэд хамгийн сонирхолтой нь эцэг эхчүүдийн дунд ажилгүй эсвэл «гэртээ байдаг» нь дийлэнх нь байсан (23 хүүхэд ингэж хариулсан). Гэсэн хэдий ч, өөрсдийн эцэг эхийн хэн нэгтэй нь эсвэл хоёулантай нь адил ирээдүйд ажилгүй байхыг хүсэж эрмэлздэг нэг ч өсвөр насныхан байгаагүй. Охид нь мөн л ирээдүйн мэргэжлээ сонгон хариулахдаа цаг үргэлж гэртээ байдаг эцэг эх эсвэл гэрийн эзэгтэй болохыг хүсэхгүй байгаа нь ажиглагдсан нь энэ бүс нутагт олон охид өсвөр насандаа эсвэл дөнгөж 20 гаруй настайдаа гэрлэх сонирхолтой байдагтай харьцуулахад сонирхолтой үр дүн юм. Энэ нь өсвөр насныхан өөрсдийн эцэг эхийн адил ажил хийхийг, ирээдүйд тэдний хийж байгаа зүйлийг давтах сонирхолгүй байгааг харуулна. Эцэг эхчүүдийн эрхэлдэг нийтлэг ажил мэргэжлийн нэг нь хувийн бизнес байх боловч үнэн хэрэгтээ өсвөр үеийхэн дунд энэ ажлыг өөрсдийн карьер болгон хүсэж эрмэлздэг, хийхийг боддог нэг ч хүн байгаагүй. Үүнтэй нэгэн адил, Нурсай тосгоны 3 хүүхэд

хариултаас харахад тэдгээрийн эцэг эх хөдөө аж ахуйн салбарт эсвэл үхэр үржүүлэхэд оролцдог боловч өсвөр насныханы хүсэл сонирхол нь энэ ажлуудыг хийх сонирхолтой гэж хариулсан нэг ч хүүхэд байхгүй байна. Хүүхдүүд өөрсдийн чөлөөт цагаараа юу хийдэг талаар хариулт өгсөн (Зураг 2).


Хүүхдүүдийн өгсөн хариултуудыг өсвөр насныхан оролцохдоо баяр хөөртэй байх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулахад ашиглаж болно. Жишээлбэл: Өсвөр насны 26 хүүхэд (хөвгүүд, охид, аль аль нь) нь бүх төрлийн спортоор тоглох дуртай гэж хариулсан нь бөхөн хамгаалалд өсвөр үеийнхэнийг оролцуулах хамгийн сайн арга зам нь спорт байж болох юм. Компьютерт суурилсан үйл ажиллагаа нь түгээмэл байдаг нь онлайнаар олон улсын хамгааллын үйл ажиллагаанд өсвөр насныханыг оролцуулах нь шилдэг арга байж болох юм.

Ашибай, Нурсай тосгодын өсвөр үеийнхэний дунд хийсэн ярилцлага, залуу байгаль хамгаалагч нараас авсан аман судалгаанд үндэслэн хэд хэдэн оролцооны талаарх зөвлөмж боловсруулав. Сэтгэл судлалын салбарт байх өсвөр үеийн үүрэг оролцооны талаар бичигдсэн ном зохиолд үндэслэн өсвөр үеийнхэний зан авирыг өөрчлөхөд чиглэсэн зөвлөмжийг боловсруулсан бөгөөд бусад үйл ажиллагаатай нэгэн адил ухуулга сурталчилгааг дэмжих явдал юм:

Гэрийн даалгавар хийх клуб болон хувийн хэвшлийн сургалт нь өсвөр насныханы хүсэл эрмэлзлийг дэмжих, илүү итгэл урам зориг өгөхөд түлхэц өгнө.

Өсвөр насныхны ирээдүйн ажил мэргэжлийн таамаглалд үндэслэсэн хөгжилтэй үйл ажиллагаа нь тэдэнд илүү сонирхолтой байж болно. Жишээлбэл, “Барилгачин” болох хүсэл эрмэлзэлд тулгуурлан шувууны үүр, бөхөнгийн хоргодох нуувчийг барих, эсвэл “Жолооч” болох хүсэл эрмэлзэлд тулгуурлан цагдаагийн машин эсвэл, байгаль хамгаалагчийн машин жолоодох арга барилд сургах зэргээр өсвөр үеийнхэний зан авирт эерэгээр нөлөөлөх загваруудыг боловсруулан хэрэгжүүлж болох юм.

Бөхөн хамгаалах өдөртэй холбон хийж болох жилийн туршид үргэлжлэх бөхөнтэй холбоотой



Зураг 1. Өсвөр үеийнхэний хүсэл эрмэлзлийг тэдний ирээдүйд хийхээр таамаглаж буй ажилтай харьцуулсан байдал


үйл ажиллагааг өсвөр насныханд (эсвэл тэдний эцэг эхэд) хэзээ ч мартагдашгүйгээр зохион байгуулах хэрэгтэй. Тухайлбал, зохион бүтээх болон хамгаалын санаа өгсөн шагнал урамшуулал бүхий бөхөнгийн түүхийн талаарх тэмцээн, уралдаан хийж, оролцогчдын ирүүлсэн бүтээлээр богино хэмжээний түүхийн ном хэвлүүлэх, ТББ-аас ирүүлж буй шмнэ ном хэвлэлийг унших уншлагын цаг эсвэл тал хээрийн уран бүтээлийн уралдаан гэх мэт байж болно.

Тосгоныхон хээрийн ургамал, ан амьтныг дүрсэлсэн ханын зургаар өөрсдийн гэрийн ханыг чимэглэх талаар өсвөр үеийнхэнээс асууж болох бөгөөд эсвэл тэдний үе тэнгийнхэнээс бүрдсэн шүүгчдэд өөрсдийн авъяас чадварыг харуулах, мөн өсвөр насныхан өөрсдөө, эсвэл ТББ-уудаар дамжуулан өөрсдийн бүтээсэн дуу хөгжим видеог онлайн хэлбэрээр байрлуулж, бөхөн дуулах клуб хэлбэрээр зохион байгуулж болно.

Янз бүрийн нас, нийгмийн бүлгийн төлөөлөл буюу орон нутгийн засаг захиргаа, цагдаа, эцэг, эхийн төлөөллийг оролцуулан баг бүрдүүлж, бөхөнгийн логотойгоор өөрсдийн тосгоны өмнөөс бусад тосгодтой хамт тэмцээнд оролцсоноор өсвөр үеийнхэнд урам зориг оруулахад нөлөөлж болох юм

Тал хээрийн зэрлэг ан амьтны клубд суурилсан хээрийн аялал, үйл ажиллагаа, тэмцээн, тоглоом, суралцах үйл явцыг илүү их зохион байгуулж, аялал, залуу үеийнхэнд зориулсан үйл ажиллагаа, эцэг эхийг хүүхдүүдийг суралцах болон байгаль дэлхийн талаар хамтдаа сурч мэдэх урам зоригоор урамшуулах

Өгүүлэл (үргэлжлөл)



Зураг 2. Өсвөр үеийнхэнд зориулсан үйл ажиллагааны чөлөөт цаг

үүрэгтэй “ивээн тэтгэгч” нарыг нийгмийн янз бүрийн давхаргын гишүүдээс сар бүр сонгон уг клубүүдтэй хамтран ажиллуулж болох юм.

Өсвөр үеийнхэн уугуул нутгийнхаа талаар илүү их туршлагыг олж авах, байгаль дэлхийтэйгээ харьцах хандлагыг сайжруулах, өрөвдөн энэрэх сэтгэл, урам зоригийг дэмжин ажиллах үйл ажиллагааг Тал хээрийн зэрлэг амьтан хамгаалах клуб эсвэл ТББ-ийн хамгааллын ажилд тусалж буй өсвөр насны хүүхдүүийг оролцуулан хийх ёстой бөгөөд эдгээрийн аль аль нь бөхөн хамгаалалд туслах боломжийг нээж, үе тэнгийнхэндээ үзүүлэх нөлөөллийг бий болгосноор найз нөхөд, ах дүү нар нь мөн энэ ажилд оролцохыг хүсэх болно.

ТББ-ууд нь зөвхөн Бөхөн хамгаалах өдөр болон тэдгээрт шаардлагатай мэдээллийг цуглуулахаас гадна сургуулиуд дээр, багш нартай хамтран хичээлийг хэрхэн илүү сонирхолтой, интерактив хэлбэрт орруулах талаар санаа өгч, тодорхой хөтөлбөрийн дагуу аль хэдийнээс хэрэгжиж байгаа зэрлэг амьтан хамгааллын хичээлийг зохион байгуулах зэрэг ажиллагаа явуулах бүлэгт өсвөр насныхныг түлхүү хамруулах хэрэгтэй.

ТББ-ууд өсвөр насныханд зориулан тэдгээрт тулгарч буй шалгалтын үнэлгээ, эсвэл

санхүүгийн хүндрэлтэй байдлаас үл хамааран их сургуульд заагдаж байгаа байгаль хамгаалах хичээлийн дагуу богино хэмжээний курс санал болгож болох юм.

Орон нутгийн уламжлалтай холбогдуулан бий болгосон үйл ажиллагаанд бүлэг нөхөрлөлүүдийг илүү түлхүү оролцуулсанаар хамгааллын талаарх мэдээллийг нэмэгдүүлнэ.

Өсвөр насны хүүхдийн зан авирыг ойлгох зорилгоор мэтгэлцээний багийг бий болгож, эерэг болон сөрөг лекц, зураглал ба мэтгэлцээнийг ашигласнаар өсвөр насны хүүхдүүд шийдлийг өөрсдөө гаргаж ирэх болно.

Шинэ чиг хандлагыг илэрхийлсэн хамгааллын орчин үеийн үйл ажиллагаа нь шинэ зүйлийг байнга туршин үзэж байдаг өсвөр насны хүүхдүүдийн сонирхлыг татаж, энэ “хандлага”-д гадаадын мэргэжилтнүүд эсвэл алдартнуудыг оролцуулах нь өсвөр үеийнхний хүсэл сонирхолыг улам бүр татах болно.

Хотын өсвөр насныханы тусын тулд нийгмийн маркетингийн арга техникийг ашиглах эсвэл 2014 онд хийгдсэн “ямар ч оо энгэсэггүй өөрийн зураг” эсвэл бөхөнтэй холбоотой “хувин элсний сорилт” гэх мэт хамгааллын үр дүнг өсвөр үеийнхэнээр дамжуулан мэдээлэл өгөх кампанит ажил зохион байгуулж болно.

Бид энэ ажлыг санхүүжүүлэн дэмжсэн Ховордсон зүйлийг хамгаалах хүмүүсийн сан болон болон Диснейн Зэрлэг амьтдыг хамгаалах санд маш их талархаж байна. Бид АНУ-ын ОУХА-ны санхүүжилтээр, Олон улсын амьтан, ургамал хамгаалах нийгэмлэгээр дамжуулан хэрэгжиж буй Устюртын ландшафт хамгаалх санаачлага төсөлд талархлаа илэрхийлье. Энэ хураангуйд үндэслэн бүрэн хэмжээний ажлыг доорхи линкээр авна уу. <http://www.iccs.org.uk/publications/thesis-archive-msc-con-sci/>

гаргах тохиолдолд муудсан дээжинд байх материалыг боловсруулах зорилгоор ашиглагдав.

Маш бага ДНХ-ийн агууламж бүхий нунтаг хэлбэртэй 2 бөхөнгийн эврээс ДНХ ялгахдаа түүвэрлэсэн ПГУ-ыг хоёр удаа хийсэн.

Өнөө үед хууль эрх зүйн БНХАУ-ын дорно дахины уламжлалт анагаах ухаанд бөхөнгийн эврийн хууль ёсны хангамж нь Зэрлэг амьтан ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенци худалдааны хориг хэрэгжүүлэхээс өмнө цуглуулсан эврийн нөөцөнд тулгуурлан хийгддэг бөгөөд энэхүү хууль ёсны эврийн нөөц удаан хугацаанд ашиглагдан шавхагдаж байна.

Өндөр ашиг олох зорилгоор үе үе бөхөнгийн эврийг хууль бусаар худалдаалах явдал байсаар байна. Бөхөнгийн эвэр нь морфологоороо бусад зээрийн эвэртэй адил учир зарим худалдаачид сайн эврийг энэхүү чанар муутай эврээр орлуулан жинхэнэ эвэр гэж хэрэглэгчдийг хууран мэхлэсээр байна. Энэ шинэ арга нь бөхөнгийн эврийн хил дамнасан хууль бус худалдааг таслан зогсоох болон уламжлалт анагаах ухааны зах зээл дээр байгаа бөхөнгийн эвэрт хяналт тавих үр дүнтэй арга хэрэгсэл болно.

Редакторын тэмдэглэл: Экологи бө Эволюци сэтгүүлд хэвлэгдсэн өгүүллийг бүрэн эхээр нь татаж авахыг хүсвэл доорхи линкеер холбогдоно уу: <http://onlinelibrary.wiley.com/doi/10.1002/ece3.1457/full>

Шинэ хэвлэл

Зүүн Европ болон Сибирээс олдсон бөхөнгийн 4 дэхь толгой: *Saiga borealis* болон *Saiga tatarica* нь нэг зүйл үү эсвэл хоёр зүйл үү?


Урсзула Ратажзак болон бусад. Польш, Вроцлавын их сургууль, Биологийн ШУ-ны салбар, Хүрээлэн буй орчны биологийн хүрээлэн, Палеозоологийн тэнхим

Плейстоценийн үед бөхөн тогтвортой байршдаггүй, байнга нүүдэллэдэг, сүрэлгэн амьдардаг Еврази, Хойд Америкийн өргөн уудам газар нутагт амьдардаг байсан бөгөөд тэдгээрийн тархалт нь сүүлийн мөстлөгийн үед хамгийн их хэмжээтэй байв. Өнөөгийн байдлаар энэ зүйлийн тархалт Төв Азид цөөн тасархайтсан популяциар хязгаарлагдаж байна. *Saiga borealis* болон *S. tatarica* гэсэн бөхөнгийн хоёр хэлбэр тодорхойлогдсон. Эхнийх нь Голоценийн эхэн үед устсан бол дараагийн хэлбэр нь Плейстоценоос өнөөг хүртэл амьдран иржээ. Эдгээр нь хоёр зүйл үү эсвэл *S. tatarica*-гийн хоёр дэд зүйл үү гэсэн асуудал маргаантай байдаг. Хэвлэлийн мэдээ зэргийг хамруулсан Евразийн олон дээжний эврийн хэмжилт болон толгойн ясанд хийсэн бидний харьцуулалтаар эдгээр ангилалзүйн нэгжийн хооронд ихээхэн ялгаа илэрсэн. *S. borealis* нь зарим гавлын ясны хэмжилтүүдээр *S. tatarica*-гаас том байсан бөгөөд *S. tatarica* нь эврийн суурь том голчтой байдгаар тодорхойлогддог байсан. Гэвч, энэ ялгаа нь

цөөн хэдэн хэмжилтийн онцлогоор илэрхийлсэн бөгөөд дүн шинжилгээ хийгдсэн бүх хэмжилтүүд нь наад зах нь хэсэглэн давхцсан байсан нь хоёр ангилал зүйн нэгж үнэндээ нэг зүйл биш байж болохыг харуулж байна. Манай дүн шинжилгээ нь *S. tatarica*-ний гавлын яс нь сүүлчийн мөстлөгийн эцэст палеогеограф болон уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хэд хэдэн хэмжилтээр жижигрэх үйл явц явагдаж популяцийн тоо толгой буурч эхэлсэн. Бид *S. borealis* болон *S. tatarica* янз бүрийн газар зүйн дэд зүйлүүдийн хооронд зөвхөн зарим нэг хэмжилт дээр мэдэгдэхүйц ялгаатай байгааг илрүүлсэн. *S. borealis* болон *S. tatarica*-ийн ялгаа нь Плейстоценийн үед байсан бөхөнгийн популяцийн биогеографийн өөрчлөлтөөс үүдэн төстэй дэд зүйл хэмжээнд хүргэсэн байж болох юм.

Редакторын тэмдэглэл: Олон улсын сэтгүүлд энэ өгүүлэл бүрэн эхээрээ хэвлэгдсэн: <http://www.sciencedirect.com/science/article/pii/S1040618215009088>

Зарлал



Бөхөнгийн нөөцийн төвийн талаарх шинэ мэдээ

Карлин Сэмюэль - SCA Захиргааны туслах ажилтан

Бөхөнгийн нөөцийн төвд саявтархан зарим нэг өөрчлөлт, шинэчлэлтийг хийсэн шинжээчдийн багт баярлалаа. Одоо уран зохиол, зураг болон видео санд хайлт хийж болно. Зочид ном бүтээлийг зохиогчоор эсвэл төрөл, жилээр, зургийг гэрэл зурагчны нэрээр эсвэл нэр төрлөөр тус тус хайж болно. Бид дээрх хоёр хэсэгт мөн ашигтай, шинэ «нийтэд зориулсан» хайлтыг оруулж байна.

Бид сайтад олон шинэ контентууд нэмсэн бөгөөд энэ жилийн эхээр ОХУ-ын Степной ДЦГ-т айлчилсан Андрей Гилев, Карина Каренина нарын авсан бөхөнгийн гайхалтай зургийг мөн оруулсан (Ред: тэдний өгүүллийг дээрээс хар). Шинжлэх ухааны мэдээ, төслийн мэдээллийн тогтмол шинэчлэлтүүдийг та Нүүр хуудас эсвэл Оршил хэсэгийн аль алинд хандан мэдээ мэдээллийг шалгаж болно.

Та хэзээ нэгэн цагт Бөхөнгийн мэдээнд нийтлэгдсэн сонирхолтой нийтлэлийг уншсан хэдий ч ямар өгүүлэл басныг санахгүй байгаа

бол бид англи, орос сайтын хэрэглэгчдэд өгүүлэл тус бүрийн онцлог зүйлийг сонсох, гүйлгэн харах ашигтай хэрэгслийг нэмж оруулж өгсөн. Үүнтэй ижил функцийг Хятад болон Казах сайтанд мөн удахгүй оруулах болно. Хэрвээ та “бөхөн судлаач” нарыг хайх хэрэгтэй бол сайтад мөн шинэ нэрсийг оруулж өгсөн.

Энэ чухал ач холбогдолтой хэсэгт юу нэмэхийг хүсэж байгаагаа бидэнд хэлнэ үү.

2016 оны эхээр хийгдэх шинэчлэлтийн ажлуудад: Казах, Орос, Хятад хэл дээрх сайтыг дуусгах, Боловсролын хэсгийг сайжруулах, зураг болон видеоны тайлбарууд хийх, Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах конвенцийн контент нэмэх зэрэг асуудлууд хамрагдсан. Хэрвээ бид нэмэлт санхүүжилт олж чадвал, цаашид бөхөнтэй холбоотой ГМС-д суурилсан мэдээлэл, Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг худалдаалах конвенцийн талаарх хуудсыг нэмж оруулах болно.

Өгүүлэл, боловсролын материал, бүтээл, зураг гэх мэт ямар нэгэн мэдээллийн сан байгаа бол бөхөн хамгаалах нийгэмлэгийн Алёна Чукатинатай доорх хаягаар холбогдон хандивлана уу. alyona.chukhatina@acbk.kz.

Эдгээр шинэчлэлийг явуулахад урам зориг, туршлага, дэмжлэг үзүүлсэн Аби Салмон, Алёна Чукатина, Сиемпре шийдэл ХХК-ийн

Стив Морган нарт талархал илэрхийлье. Хятад хэлнээ орчуулсан Гуйхонг Занг болон орос хэлрүү орчуулгыг хийсэн Алёна нарт талархаж байна. Бөхөн хамгаалах нийгэмлэгийн үр дүнтэй мэдээллийн сан болох Бөхөнгийн нөөцийн төв рүү дараах хаягаар зочилно уу: www.saigaresourcecentre.com

Бөхөнгийн баатар

Юрий Арылов: Урам зориг нь бөхөнг хамгаалалд хангалттай биш юм

Бөхөнгийн мэдээний 19 дугаарт бид Халимагийн БНУ-ын Зэрлэг амьтан хамгаалах төвийн гунигтай мэдээг уншигчдтайгаа хуваалцсан. Хэрэв та санаж байгаа бол 2014 оны намар Халимагийн Бүгд Найрамдах Улсын Засгийн газар 15 жилийн турш үйл ажиллагаа явуулж байгаа төвийг татан буулгахаар шийдвэрлэсэн. Гэсэн хэдий ч, эдгээр бүх жилүүдэд уг төвийн захирал байсан профессор Юрий Арылов сайн дураараа үргэлжлүүлэн ажиллаж, Черные Земли нөөц газар уг төвийг шилжүүлэн авна гэж найдаж шаардлагатай бүх бичиг баримтыг бэлтгэж байна. Энэ нь олон жилийн турш бөхөнгийн төлөө хийж буй профессор Арыловын хүсэл болох нь тодорхой юм.

Юрий Николаевич Арылов Халимагийн БНУ-ын Зэрлэг амьтан хамгаалах төвийн захирал, Биологийн ухааны доктор, Халимаг улсын их сургуулийн профессор болон Халимагийн БНУ-ын шинжлэх ухааны гавьяат ажилтан юм. Юрийгийн шинжлэх ухааны сонирхлын хүрээ маш өргөн бөгөөд сүүлийн 24 жилийн турш тууртан амьтдын экологийн судалгааг, ялангуяа бөхөн, популяцийн биологийн янз бүрийн салбар дахь экологийн боловсрол, байгаль орчныг хамгаалах чиглэлээр идэвхтэй ажиллаж байна.



Юрийн Арыловын төвд төрсөн бөхөнгийн янзаг
(© Центр диких животных РК)

Редактор: Анх хэзээнээс бөхөнг сонирхож эхэлсэн бэ?

Би 1943 онд миний эцэг эхийн нэгэн адил маш олон цөлөгдсөн халимаг хүмүүс амьдардаг байсан Сибирийн Ханты Мансийск өөртөө засах бүс нутгийн Сургут хотод төрсөн бөгөөд бид бүгд арслан заан, хирстэй хамт амьдарч байсан бөхөнг мэддэг байсан. Сургуулиа төгссөний дараа би миний өвөг дээдсийн уугуул хот болох Элиста-д эргэн ирж, Халимагийн улсын Их сургуулийн

Хөдөө аж ахуйн факультетэд элсэн орлоо. Хэдийгээр суралцах эхний жилүүддээ гэрийн мал судлахад бүх амьдралаа зориулахаар шийдвэрлэсэн байсан ч би уугуул нутгийнхаа зэрлэг ан амьтдыг судлахад их цаг хугацаа зарцуулсан. Нэг л өдөр би арслан зааны богиносгосон хувилбарыг санагдуулам их биетэй хачин царайтай энэ амьтанд татагддаг болсон. Халимагийн талд тухайн үед маш элбэг байсан бөхөнг нарийн судлаж амжаагүй байсан. Төр засгийн зүгээс ч гэсэн хээрийн ургамлыг талхлан гэмтээж буй бөхөнгийн тоо толгойг бууруулах тусгай хөтөлбөрийг боловсруулж байв. Тэр ч байтугай улсын хөдөө аж ахуйн байгууллага бөхөн агнах үйл ажиллагааг гүйцэтгэж байв. Халимаг нь тухайн үед бөхөнгийн махны борлуулалтаас ихээхэн ашиг олж байсан.

Редактор: Та хэзээнээс бөхөн судлаж, түүний хамгаалал дээр ажиллаж эхлэсэн бэ?

ЗХУ-ын задрал 1980-аад оны сүүлээр эхэлж, улс орны хөдөө аж ахуйн салбар уналтанд орсон. Би Черные Земли нөөц газрын

орлогч захирлын албан тушаалд 1991 онд томилогдсон. Энд ирсэнээр бөхөн, түүний экологийн талаар аль болох их зүйл суралцах миний мөрөөдөл байсан ба энэ сайхан амьтныг хамгаалах нь миний амьдралын зорилго болсон. ОХУ-д бөхөнгийн популяцийн төлөв байдал муудаж эхлэсэн 2001 онд Халимагийн БНУ-ын ерөнхийлөгч Кирсан Илюмжинов надад бөхөнг хагас зэрлэг нөхцөлд үржүүлэх зорилго бүхий Зэрлэг амьтан хамгаалах төвийн даргын ажлыг санал болгосон. Ингээд Элиста хотоос 70 км зайд төв байгуулахаар хуваарилан өгсөн 800 га талбайд бид Яшкул үржүүлгийн төвийн ажилтнууд болон зочдод орон сууцны барилга, бөхөнд зориулан хашаа барьж, шинжлэх ухааны судалгаа хийх болон янз бүрийн нийгмийн давхаргад амьдарч буй хүн амын сургалт сурталчилгаа, экологийн боловсрол олгоход шаардагдах бүх дэд бүтцийг бий болгосон. Бид Бөхөнгийн мэдээнд энэ төвийн талаар аль хэдийн бичсэн.

Редактор: Таны ажлын нэг өдөр хэрхэн өнгөрдөг вэ?

Ер нь өдөр тутмын, долоо хоногийн амралтын өдрүүд нь бидний хувьд маш их адилхан юм. Би ихэвчлэн тэнд юу болж байгааг мэдэхийн тулд Яшкул үржүүлгийн төвийн ажилтнууд руу залгаснаар миний ажлын өдөр эхэлдэг. Эдгээр яриа нь миний үлдсэн өдрийн ажлын хуваарийг тодорхойлдог. Төвийн үйл ажиллагаатай холбоотой захиргааны асуудал нь өдрийн туршид миний цаг хугацааны ихэнх хэсгийг эзэлж байна. Миний өдөр тутам хийдэг бусад ажлууд нь захидалд хариулах, тайлан бэлтгэх, дараагийн өдрүүдийн төлөвлөгөө гаргах болон бусад байгууллаас ирсэн төлөөлөгчидтэй уулзах зэрэг болно. Би Их Сургуульд Экологийн сургалтыг мөн идэвхтэйгээр зааж байна. Залуу үеийнхэнтэй хамт ажиллаж байгаадаа би маш таатай байдаг. Ихэвчлэн хөдөө, орон нутгийн сургуулиудад зочилж, бөхөнгийн тухай, байгаль орчныг хамгаалахад юу шаардлагатай байгаа тухай, тэдний уугуул нутгийн зэрлэг ан амьтдын тухай хүүхдүүдэд хэлдэг.

Редактор: Та бидэнд бөхөнгийн тухай сонирхолтой түүх ярьж өгнө үү?

Хар-Булаг (Элиста-гаас 17 км зайтай) хэмээх газарт 2003 онд манай үржүүлгийн төв байрлаж, бөхөнгүүдээ нэмэлт тэжээлээр хооллож байсан. Эдгээр амьтдаас хамгийн найрсаг нь Пятнашка нэртэй залуу бөхөн байсан (оросоор «цоохор» гэсэн утгатай). Пятнашка 2.5 сартай байх үедээ баруун өмнөх хөл нь хугарч гэмтсэн. Бид даруйхан



Профессор Ю.Н.Арылов хээрийн судалгаа хийж байгаа нь © CWA

хугарсан ясанд чиг барьж боосон. Нэг сар хагасын дараа Пятнашкагийн хөлөөс гипсийг салган авч, түүний хөлийг амраасан боловч тэрээр үл мэдэг доголсоор байсан тул үүнийг түүний нэртэй холбон Пятнашка-Хромоношка (доглон гэж орчуулж болно) гэж нэрлэсэн. Энэ эрэгчинг 2005 онд Яшкул дахь үржүүлгийн төв рүү шилжүүлэн суурьшуулсан бөгөөд тэнд маш сайн байгаа. Түүний нэрийг дуудах үед тэр хариу өгдөг байсан.

Редактор: Таны ажилд тулгарч буй үндсэн асуудал юу вэ?

Одоогийн байдлаар сайн мэдэгдэж буй шалтгааны тухай ярихад надад хэцүү байна. Гэсэн хэдий ч, энэ салбарт хуримтлуулсан миний баялаг туршлага нь үндсэн асуудал бол хүрэлцээ муутай санхүүжилт эсвэл огт санхүүжилтгүй байх явдал болохыг харуулж байна (хамт ажиллаж байгаа бүх хүн надтай санал нэг гэж бодож байна). Харамсалтай нь, зөвхөн урам зориг нь бөхөнг тэжээх болон ус худалдан авах «валют» болгон ашиглах боломжгүй бөгөөд хангалттай биш юм.

Редактор: Таны ажилд тулгарч буй бэрхшээлийг арилгах арга замын талаарх таны бодол?

Дэлхий даяар ярьж буй экологи, байгаль орчныг хамгаалах асуудал нь Засгийн газрын нийгмийн хөгжлийн стратегид тэргүүлэх чиглэл болох ёстой. Тиймээс энэ газар нутаг үлдэгдэл мөнгөөр санхүүжихээс илүүтгээр харин ч санхүүгийн дэмжлэг нь өндөр түвшинд байх ёстой. Байгалийн экосистемийн бүх бүрэлдэхүүн хэсгийг хамгаалах нь бүх түвшиний, албан хаагч төдийгүй жирийн иргэдийн хувьд ч үндсэн зорилтуудын нэг болох ёстой.



Бүлэг нөхөрлөлийн үзэл бодол
(© Центр диких животных РК)

Редактор: Таны ажлын хамгийн сайхан хэсэг нь юу вэ?

Миний ажлын хамгийн сайхан хэсэг нь таныг маш чухал салбарт оролцож байгааг ойлгуулах явдал юм. Энэ нь зүгээр л шууд бөхөнтэй ажиллаж буй бидний ажилд оролцох биш, харин өөрсдийн орны өнцөг булан бүрээс болон хилийн чанадаас Яшкул үржүүлгийн төвд ирж ажиллаж буй шинжээчидтэй холбогдох явдал. Хүүхдүүд бас миний мэргэжлийн үйл ажиллагаанд чухал орон зайг эзэлдэг бөгөөд тэд бидний тэдэнд хэлж, харуулсан бүх зүйлийг тусган авч, ирээдүйд бидний хийж байгаа зүйл шиг бидний газарт бөхөн болон зэрлэг ан амьтдыг хамгаалах болно. Миний хамгийн чухал ололт нь хагас зэрлэг нөхцөлд бөхөн үржүүлэх аргачлалыг ОХУ-ын шинжлэх ухааны янз бүрийн байгууллагын судлаачидтай хамтран боловсруулсан явдал юм. 2015 онд Яшкул үржүүлгийн төв нь 15-р үеийн нялх бодгалийг хүлээн авсан бөгөөд энэ нь бид харьцангуй тогтвортой, амьдрах чадвартай

жижиг популяцийг бий болгож чадсан гэсэн үг юм.

Редактор: Бөхөн хамгааллын хэтийн төлөв юу вэ? Тухайн зүйлийн эсэн мэнд үлдэхэд туслах хамгийн чухал, үндсэн алхам нь юу вэ?

ОХУ-д бөхөнгийн нөхцөл байдал зүгээр л аймшигтай байна. Түүнчлэн Казахстан дахь сүүлийн үеийн эмгэнэлт явдлаас үүдсэн их хэмжээний үхэл үгээр өгүүлэхийн аргагүй. Бид олон тооны байгалийн гамшиг, улс орны эдийн засгийн хүндрэл, өвчин гэх мэт зүйлээс шалтгаалан энэхүү өвөрмөц зүйлийг алдаж байна. Бүс нутаг болон үндэсний түвшинд аль алинд нь санхүүжүүлж болох бодит үйл ажиллагааны төлөвлөгөөг аль болох хурдан боловсруулах нь үнэхээр чухал гэж бодож байна. Энэ талаар хангалттай санхүүгийн дэмжлэгтэй үйл ажиллагааны бодит төлөвлөгөөг боловсруулсан нь сайн үр дүнгээ өгч бөхөнгийн популяци нь 10 жилийн дотор 10 дахин өссөн. Бүгд Найрамдах Казахстан улсаас суралцах ёстой (2004 онд 23-24 мянган бодгаль байсан бол 2014 онд 260-280 мянга хүрсэн)

Редактор: Та ховор амьтдыг судлах, хамгаалах чиглэлээр хорь гаруй жилийн турш ажиллаж байна. Эдгээр жилүүдэд танд ямар өөрчлөлт ажиглагдаж байна вэ? Энэ салбар дахь одоогийн чиг хандлага юу вэ?

Харамсалтай нь, ихээхэн хүчин чармайлтыг үл харгалзан уг зүйлийг бүрмөсөн устахад хүргэж болзошгүй сүүлийн жилүүдэд бөхөнгийн популяцийн бууралт явагдсаар байна. Би гутранги үзэлтэн биш ээ. Гэхдээ би өнөөдөр ямар нэгэн эерэг хандлагыг харахгүй байна

Талархал

Бид Бөхөн хамгаалах холбооны ажлыг мөнгөн хандив, цаг хугацаараа дэмжин ажилладаг бүх хүмүүст гүн талархал илэрхийлэхийг хүсч байна. Ялангуяа Зэрлэг амьтан хамгаалах сүлжээний ажилтнууд, сайн дурынханд тэдний дэмжлэг, зөвлөгөө болон сүүлийн үеийн үйл ажиллагаанд өгөөмөр хандив өгч буй АНУ-ын олон нийтийн гишүүдэд талархаж байна. Бид энэ хэвлэлийг дэмжиж ажилласан ЗАНЗХК, Зэрлэг амьтан хамгаалах сүлжээ, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь салбар, Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Хятадын салбар зэрэг байгууллагад гүнээ талархаж байна.







SAIGA CONSERVATION ALLIANCE

Saiga Conservation Alliance
www.saiga-conservation.com

Saiga Resource Centre:
www.saigaresourcecentre.com

Saiga Merchandise:
www.saigacraft.org

Email: mail@saiga-conservation.com

©Saiga Conservation Alliance 2016 /
Registered charity England and Wales

Image © Andrey Gilyov
& Karina Kareina